



# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2025 оны 01-р сар | ДУГААР 86

## АГУУЛГА

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

2-3

Зохицуулалтын мэдээ

20 жилийн ойн мэндчилгээ



4-7

Бодлогын нийтлэл

8-9

Ярилцлага



10

Тогтвортой санхүүжилт



11

Компанийн засаглал, комплайнс

12-13

Финтек ба регтек



14-23

Судлаачийн индэр



24-25

Зээл авахад анхаарах алтан дүрэм



26-27

Олон улсын зах зээлийн мэдээ



28

Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс



## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙН МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хариуцлагатай, нэр төртэй үйлсэд хүчин зүтгэж, мэдлэг туршлага, оюун ухаан, итгэл сэтгэлээ зориулан ажиллаж байгаа үе, үеийн удирдлага, хамт олон, мэргэжлийн байгууллагынхан, салбарын бүхий л оролцогчид, харилцагч, үйлчлүүлэгч Та бүхэндээ Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсаны 20 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлье.

УИХ-аас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталж, 2006 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр анхны дарга, гишүүдийг томилсноор Монгол Улсад санхүүгийн зах зээлийн нэгдсэн хяналт, зохицуулалтын байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсан түүхтэй.

1994 онд байгуулагдсан Үнэт цаасны хорооны суурин дээр Монголбанкны чиг үүргээс банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны салбарыг, Улсын мэргэжлийн хяналтын газрын эрхлэх асуудлаас даатгалын салбарыг тус тус хариуцан авч үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өнөөдөр 5930 зах зээлийн оролцогчийг зохицуулалтдаа хамарсан, олон улсын санхүүгийн зохицуулагчдын эгнээнд зүй ёсоор нэгдсэн байгууллага болон өргөжөөд байна.

Монгол Улсад санхүүгийн зах зээлийн зохицуулалтын бие даасан тогтолцоо бүрэлдэн тогтсон эдгээр 20 жил бол

хариуцлага, сорилт, шинэчлэл, ахиц дэвшлээр дүүрэн он жилүүд байлаа. Олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг өргөжүүлэх, зах зээлийн ил тод, тогтвортой байдлыг хангах, харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд бодит үр дүнтэй олон ажлыг хэрэгжүүлсэн нь санхүүгийн зах зээлийн зохицуулалтын тогтолцоо төлөвшсөний тод жишээ боллоо.

Үүний бодит илрэл нь санхүүгийн зах зээлийн ДНБ-д эзлэх хувь 30.2 хувьд хүрч өссөнөөс гадна биржийн болон биржийн бус зах зээлээр дамжуулан компаниуд нийт 10.89 их наяд төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ түүхэн дээд хэмжээнд буюу 13.9 их наяд төгрөгт хүрсэн явдал юм. Мөн даатгалын салбарын хөрөнгө өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар, банк бус санхүүгийн байгууллагын хөрөнгө 27.1 хувиар, хадгаламж зээлийн хоршооны салбар 6.2 хувиар тус тус өссөн нь санхүүгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж буйг тод харуулж байна.

Энэ бүх ахиц, бодит үр дүн нь Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа шинэ шатанд гарсныг илтгэхийн зэрэгцээ хороо нь зөвхөн зохицуулагч байгууллага байхаас гадна зах зээлийн тогтвортой хөгжил, олон улсын хамтын ажиллагааг тэлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлж, ирээдүйд чиглэсэн шинэ зорилт, зорилгыг тодорхойлон ажиллаж байна.

Эдгээр амжилтын үндэс нь мэдлэг чадвар, хариуцлага, сэтгэл зүтгэлээ зориулан ажилласан үе үеийн удирдлага, хамт олны уйгагүй хөдөлмөр, түүнчлэн салбарын оролцогчид, дотоод болон олон улсын түнш байгууллагуудын итгэл, дэмжлэг билээ. Та бүхний хамтын ажиллагаа, харилцан ойлголцол нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийг шинэ шатанд гаргах бат бөх суурь болсоор ирснийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Цаашид ч хууль тогтоомж, чиг үүргийнхээ хүрээнд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, инновац, дижитал шилжилтийг дэмжих, харилцагч, үйлчлүүлэгчдийн итгэлийг хамгаалсан шударга, ил тод зохицуулалтыг хэрэгжүүлэх хариуцлагатай, чухал ажил биднийг хүлээж байна. Эдгээр зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд Та бүхний хамтын ажиллагаа, дэмжлэг цаашид ч үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл төгс байна.

Ийнхүү түүхт 20 жилийн ойн мэндийг Та бүхэндээ дахин хүргэж, Монгол Улсын санхүүгийн салбар улам бүр бэхжин хөгжиж, салбарын оролцогчдын чадавх сайжирч, эдийн засгийг тэтгэх чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ арвижин дэлгэрэхийн ерөөлийг өргөн дэвшүүлье.

### БАНК БУС САНХҮҮГИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМД ОРОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛО



Улсын Их Хурлын 2025 оны 124 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд иргэдийн хэрэглээний зээлийн хэт өсөлт, өрийн дарамтыг бууруулах, цахим зээлийн давхардлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар салбарын оролцогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Энэ үеэр банк бус санхүүгийн байгууллагаас олгох хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд тавих шаардлага, финтек зээлийн бүтээгдэхүүнтэй холбоотой цахим зээлийн давхардал, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл солилцоо, нийлүүлэлтийн асуудал зэрэг салбарын тулгамдсан асуудлуудыг хөндөн ярилцав.

Хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хорооны удирдлага, албан хаагчид болон банк бус санхүүгийн байгууллагуудын 200 гаруй төлөөлөл оролцож, санал бодлоо солилцлоо.

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2026 ОНЫ ХУРАЛДААНЫ ТОВ БАТЛАГДЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны ээлжит хуралдааны товыг тус Хорооны ээлжит 1 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Уг шийдвэрийн дагуу энэ онд хуралдаан тогтсон хуваарийн дагуу зохион байгуулагдах бөгөөд хуралдаанаар санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналттай холбоотой бодлого, шийдвэрүүдийг хэлэлцэн батлах юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны хуралдааны тов

Нэгдүгээр сар							Хоёрдугаар сар							Гуравдугаар сар							Дөрөвдүгээр сар							
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	
			1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4				1	2	3	4	
5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31		
12	13	14	15	16	17	18	9	10	11	12	13	14	15	9	10	11	12	13	14	15	13	14	15	16	17	18	19	
19	20	21	22	23	24	25	16	17	18	19	20	21	22	16	17	18	19	20	21	22	20	21	22	23	24	25	26	
26	27	28	29	30	31		23	24	25	26	27	28		23	24	25	26	27	28	29	27	28	29	30				
														30	31													

Тавдугаар сар							Зургаадугаар сар							Долоодугаар сар							Наймдугаар сар							
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	
			1	2	3					1	2	3	4	5	6	7				1	2	3	4	5				
4	5	6	7	8	9	10	8	9	10	11	12	13	14	6	7	8	9	10	11	12	3	4	5	6	7	8	9	
11	12	13	14	15	16	17	15	16	17	18	19	20	21	13	14	15	16	17	18	19	10	11	12	13	14	15	16	
18	19	20	21	22	23	24	22	23	24	25	26	27	28	20	21	22	23	24	25	26	17	18	19	20	21	22	23	
25	26	27	28	29	30	31	29	30						27	28	29	30	31			24	25	26	27	28	29	30	
																					31							

Есдүгээр сар							Аравдугаар сар							Арвандугаар сар							Арванхоёрдугаар сар												
Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня						
			1	2	3	4	5	6				1	2	3	4				1	2	3	4	5	6				1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13	5	6	7	8	9	10	11	2	3	4	5	6	7	8	7	8	9	10	11	12	13						
14	15	16	17	18	19	20	12	13	14	15	16	17	18	9	10	11	12	13	14	15	14	15	16	17	18	19	20						
21	22	23	24	25	26	27	19	20	21	22	23	24	25	16	17	18	19	20	21	22	21	22	23	24	25	26	27						
28	29	30					26	27	28	29	30	31		23	24	25	26	27	28	29	28	29	30	31									
														30																			

■ Хорооны хуралдаан болох өдөр    ■ Амралтын болон нийгээр гэмдэлэх баярын өдөр

Хуралдааны батлагдсан товыг Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны цахим хуудсанд байршуулснаар зохицуулалтын байгууллагууд, компаниуд, зах зээлийн оролцогчид болон олон нийтэд хурлын шийдвэр гаргалтын үйл явцын талаарх мэдээллийг цаг алдалгүй, нээлттэйгээр авах боломж бүрдэж байна.

### БНХАУ-ЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО, БЭЭЖИНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ АСУУДЛААР УУЛЗЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үнэт цаасны зохицуулах хороо (CSRC) болон Бээжингийн хөрөнгийн бирж (BSE)-ийн удирдлагуудтай уулзлаа.

БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулах хороотой хийсэн уулзалтад тус хорооны дэд дарга болон холбогдох газрын удирдлагууд мөн Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны Элчин зөвлөх Г.Бумцэнд, зөвлөх Ц.Эрдэнэбаяр нар оролцож, хоёр улсын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, зохицуулалтын бодлого, шинэчлэл, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов. Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц Монголын хөрөнгийн зах зээлд сүүлийн жилүүдэд гарсан ахиц дэвшил, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэвтрүүлэлт, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалж эхэлсэн туршлага, Засгийн газрын болон орон нутгийн бондын зах зээлийн хөгжил, зохицуулалтын орчны шинэчлэлийн талаар танилцууллаа.

Түүнчлэн хоёр байгууллагын 2008 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг зах зээлийн өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх, Монголын компаниудыг БНХАУ-ын хөрөнгийн зах зээлд давхар бүртгүүлэх боломжийг судлах, түүхий эд болон деривативын зах зээлийн туршлагаас суралцах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцлоо. БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулах хорооноос хамтын ажиллагааг бүх чиглэлд хөгжүүлэхэд нээлттэй байгаагаа илэрхийлсэн юм.

Харин Бээжингийн хөрөнгийн биржтэй хийсэн уулзалтын эхэнд Монголын хөрөнгийн зах зээлд хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын шинэчлэл, зах зээлийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар мэдээлэл өгч, дотоодын компаниудыг тус улсын бирж дээр давхар бүртгүүлэх боломжийн талаар санал солилцлоо.

Бээжингийн хөрөнгийн биржийн удирдлагууд мөн энэ үеэр жижиг, дунд бизнесийг дэмжих бодлого, бүртгэлийн тогтолцоо, “green channel” буюу хурдавчилсан бүртгэлийн механизм, зах зээлийн хяналт, шалгалтын тогтолцоо болон хөрөнгө оруулагчдыг хамгаалах бодлого, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй ажлаасаа танилцуулсан юм.

Талууд цаашид Монголын компаниудыг Бээжингийн хөрөнгийн бирж дээр давхар бүртгүүлэх боломжийг дэмжих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, зах зээлийн хяналт, мониторингийн тогтолцооны талаар туршлага солилцох чиглэлд хамтран ажиллахаар харилцан санал нэгдлээ.

## “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА УУЛ УУРХАЙ” СЭДВИЙН ХҮРЭЭНД “MONGOLIA'S CAPITAL MARKET CONNECTIVITY” АРГА ХЭМЖЭЭ БНХАУ-ЫН БЭЭЖИН ХОТНОО БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, олон улсын зах зээлд сурталчлах, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын компаниудад олон улсын зах зээлээс санхүүжилт татах боломжийг сайжруулах

зорилгоор “Монголын хөрөнгийн зах зээлийг холбох нь” цуврал арга хэмжээг өнөөдөр БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгууллаа.

Арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, УИХ-ын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, БНХАУ-д суугаа Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Н.Энхболд, БНХАУ-ын Хятад-Азийн Эдийн засгийн хөгжлийн ассоциацийн тэргүүн Чуан Шин Жи болон тус улсын Санхүүгийн зохицуулагч байгууллага (CSRC), Бээжингийн хөрөнгийн бирж (BSE)-ийн удирдах албан тушаалтнууд, хоёр улсын санхүү, уул уурхай, хөрөнгийн зах зээлийн төр, хувийн хэвшлийн төлөөлөл, олон улсын хөрөнгө оруулагчид оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Монгол Улсын санхүүгийн салбар, тэр дундаа хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд хурдацтай, үсрэнгүй хөгжиж хууль эрх зүйн орчин, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, арилжааны идэвх, дэд бүтэц олон улсын жишигт нийцсэн зах зээл болон төлөвшиж буйг онцлов. Тэрбээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ сүүлийн таван жилийн хугацаанд 5.3 дахин өсөж 13.9 их наяд төгрөгт, үнэт цаасны арилжааны хэмжээ 20.1 дахин нэмэгдэн 1.3 их наяд төгрөгт хүрснийг дурдан, энэ нь дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах сонирхол эрс нэмэгдсэнийг илтгэж байгааг тэмдэглэлээ. Мөн уул уурхайн салбарын бүтээгдэхүүний биржийн арилжаа жилээс жилд идэвхжиж, өнгөрсөн онд 27.79 сая тонн бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 12 хувиар өссөн үзүүлэлт болсныг дурдаад, нүүрсний экспортын 24.3 хувь, төмрийн хүдэр, баяжмалын экспортын 67 хувь нь биржээр дамжин арилжаалагдаж буйг онцлов. Уул уурхайн салбар болон хөрөнгийн зах зээлийг уялдуулж хөгжүүлэх нь Монгол Улсын эдийн засгийн чухал зорилт бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтыг татах, компаниудыг санхүүжүүлэх улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлдэг болохыг тэрбээр онцлов. Түүнчлэн энэхүү арга хэмжээ нь хоёр улсын хөрөнгийн зах зээл, уул уурхайн салбар хоорондын бодит хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан ашигтай хөрөнгө оруулалтыг дэмжих, салбар хоорондын уялдаа холбоог гүнзгийрүүлэх чухал эхлэл болно гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийллээ.

Арга хэмжээний хүрээнд Монголын хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын төлөв, зохицуулалтын орчин, хөрөнгө оруулалтын боломжуудын талаар дэлгэрэнгүй танилцуулга хийж, уул уурхайн салбарт хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах боломж, биржийн арилжааны экосистем, арилжаанд оролцох үйл явцын талаар мэдээлэл

өглөө. Харин БНХАУ–ын талаас тус улсын хөрөнгийн бирж дээрх гадаадын компаниудын бүртгэл, хөрөнгө оруулалтын боломж, уул уурхайн салбарын хөгжлийн чиг хандлагын талаар танилцуулсан юм.

“Хөрөнгө оруулалт ба уул уурхай” сэдэвт энэхүү арга хэмжээ нь Монголын хөрөнгийн зах зээл, уул уурхайн салбарыг БНХАУ–ын эх газрын мужуудад таниулан сурталчлах, хоёр улсын хөрөнгийн биржүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, дотоодын компаниудыг БНХАУ–ын биржүүдэд давхар бүртгүүлэх, хадгаламжийн сертификат гаргахад дэмжлэг үзүүлэх, гадаадын томоохон хөрөнгө оруулагчдын сонирхол, оролцоог нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан арга хэмжээ боллоо.

Түүнчлэн Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт, санхүүгийн урсгалыг татах, хөрөнгийн зах зээлээр дамжуулж технологийн шинэчлэл, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих ажлыг энэхүү арга хэмжээгээр дамжуулан эхлүүлж чадсан нь онцлох үр дүн байв.

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын зах зээлд сурталчлах, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Mongolia’s Capital Market Connectivity” цуврал арга хэмжээг 2023 оноос хойш БНХАУ–ын Шанхай, Хонгконг, Сингапур, БНСУ–ын Сөүл, АНУ–ын Нью–Йорк хотноо амжилттай зохион байгуулсаар ирсэн юм. Тус арга хэмжээнүүдийн үр дүнд Монголын хөрөнгийн зах зээлд гадаадын санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын сангууд, институциональ хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдсэн. Мөн өнөөдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороо нь олон улсын нийт 16 байгууллагатай хамтран ажиллаж, Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын сүлжээнд холбох суурийг бүрдүүлээд байна.

## САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)–ийн ээлжит хуралдаан энэ сарын 13–нд Сангийн яамны хурлын танхимд зохион байгуулагдлаа. Хуралдаанд Сангийн сайд Б.Жавхлан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Монголбанкны ерөнхийлөгч С.Наранцогт, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ариунболд болон холбогдох бусад албан тушаалтнууд оролцлоо.

Тус хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай, Макро эдийн засгийн төлөв, Олон улсын төлбөр тооцооны тухай, СТБЗ–ийн энэ оны ээлжит хурлын тов тогтоох зэрэг асуудлуудыг хэлэлцэв.



## НЭЭЛТТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Арга хэмжээг нээж Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуун хэлсэн үгэндээ, сүүлийн жилүүдэд дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах сонирхол нэмэгдэж, үүнийг даган шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ идэвхтэйгээр нэвтэрч, хөрөнгө оруулагчдын сонголт өргөжиж байгааг онцлов. Тэрбээр, 2025 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 13.88 их наяд төгрөгт хүрч, өмнөх улирлаас 5.25 хувь, өмнөх оны мөн үеэс 6.58 хувиар өссөнийг дурдлаа.

Мөн банк бус санхүүгийн байгууллагууд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар олон нийтээс санхүүжилт татах үйл ажиллагаа эрчимжиж буйг тэмдэглэж, сүүлийн таван жилийн хугацаанд банк бус санхүүгийн 10 байгууллага нийт 21 удаа нээлттэй хэлбэрээр үнэт цаас гарган, 416.85 тэрбум төгрөгийг зах зээлээс татан төвлөрүүлснийг онцолсон юм. Үүнээс харахад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хувьцаа, өрийн хэрэгслийн нэгэн адил санхүүжилт татах чухал хэрэгсэл болж, аж ахуйн нэгжүүдийн сонирхол тогтвортой нэмэгдэж байгаагийн илрэл юм. Энэ бол хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчид та бидний хамтын ажиллагааны үр дүн гэдгийг тэрбээр онцлов.

## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### Бодит цалин

Real wage

Инфляцаар засварласан цалин. Цалингийн худалдан авах чадвар, цалингаар худалдан авч болох бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ.



### Цалингийн зээл

Payday loan

Зээлийн төлбөрийг ирээдүйн цалин, түүнтэй адилтгах нөхөн олговрын орлогоор эргүүлэн төлөх нөхцөл бүхий зээл. Цалингийн зээлийн өртөг (хүү болон шимтгэл, хураамж) харьцангуй өндөр байдаг.

### Цалингийн шимтгэл, суутгал

Payroll deduction

Ажилчин, албан хаагчийн цалингаас суутгах татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл гэх мэт.

*Эх сурвалж: Эдийн засаг,  
санхүүгийн нэр томъёоны  
тайлбар толь*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улс 1991 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж, өмч хувьчлалын бодлогыг хэрэгжүүлснээр дотоодын хөрөнгийн зах зээлийн үндэс суурь тавигдсан. Үүнээс хойш 35 жилийн хугацаа өнгөрч, энэхүү салбар нь үе шаттайгаар хөгжиж, өнөөдөр орчин үеийн, олон улсын жишигт нийцсэн зах зээл болон төлөвшиж байна.

Өмч хувьчлалын хүрээнд 1991 онд Монголын хөрөнгийн бирж болон анхны брокерийн пүүсүүд байгуулагдаж, 1992 онд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах анхны арилжаа явагдсан. Улмаар 1994 онд Үнэт цаасны тухай хууль батлагдаж, Үнэт цаасны хороо байгуулагдсан бол 1995 оноос үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр зах зээлийн бодит үйл ажиллагаан өрнөсөн.

Зах зээлийн хөгжил, шаардлагын дагуу 2002 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэгдэж, 2003 онд төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг Монголын хөрөнгийн биржээс салган, 100 хувь төрийн өмчит “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг байгуулсан нь дэд бүтцийн чухал шинэчлэл болов.

Монголын хөрөнгийн зах зээлд 2001 онд анхны өрийн хэрэгсэл, 2005 онд анхны IPO гарч, мөн онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан. Үүний үр дүнд Үнэт цаасны хорооны суурин дээр даатгал, бичил санхүүгийн салбарын хяналт, зохицуулалт нэгтгэгдэн, өдгөө Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсаны 20 жилийн ой тохиож байна.

2010 онд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль батлагдсанаар санхүүгийн урсгалд суурилсан шинэ хэрэгслийг зах зээлд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Харин 2013 онд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдаж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг төлөвшүүлэх, олон улсын жишигт нийцсэн хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлэв. Үүнтэй уялдан кастодиан банк, давхар бүртгэл, мэдээллийн ил тод байдал, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх зэрэг шинэ зохицуулалтууд нэвтэрч, 2015 оноос кастодианы үйлчилгээ Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн.

2017 онд анхны хувийн үнэт цаасны бирж үйл ажиллагаагаа эхлүүлж, 2020 онд давхар бүртгэлийн эрх зүйн орчин бүрдэн, гадаадын биржид бүртгэлтэй компанийн үнэт цаас Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдав. Мөн үнэт цаасны арилжааны дараах төлбөр тооцоог T+2 горимд шилжүүлж, төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) зарчмыг нэвтрүүлснээр төлбөр тооцооны тогтолцоо олон

улсын стандарттай нийцсэн.

Санхүүгийн зохицуулах хороо 2020 онд биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмыг баталж, 2021 оноос анхны арилжаа эхэлснээр Монголын хөрөнгийн зах зээл биржийн болон биржийн бус гэсэн хоёр тулгуурт бүтцэд шилжив.

2021 онд үнэт цаас, өрийн хэрэгслийг нийтэд санал болгон гаргах үйл явцыг хялбаршуулах зорилгоор бүртгэлийн холбогдох журмууд шинэчлэгдэж, зах зээлийн үр ашиг, зохицуулалтын уялдаа сайжирсан. Үүний үр дүнд дотоодын аж ахуйн нэгжүүд “Ногоон таксономи”-д нийцсэн төсөл, хөтөлбөрөө санхүүжүүлэх зорилгоор ногоон бонд гаргах боломж бүрдсэн.

2022 онд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой журмууд шинэчлэгдэж, нээлттэй сангууд шинээр бий болж, хөрөнгө оруулагчдын идэвх, зах зээлд итгэх итгэл нэмэгдэв. Мөн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдаж, уул уурхайн бүтээгдэхүүнийг ил тод, зах зээлийн бодит үнээр арилжаалах эрх зүйн орчин бүрдсэн.

Банкны тухай хуульд орсон 2021 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд системийн нөлөө бүхий банкуудын хувьчлал эхэлж, 2023 онд таван банк амжилттай IPO хийснээр 446.79 тэрбум төгрөг татан төвлөрүүлж, зах зээлийн үнэлгээ 5.7 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Түүнчлэн анхны ногоон бонд, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа бодитоор хэрэгжив.

2024 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд реформын шинжтэй нэмэлт, өөрчлөлт орж, 2025 оноос хувьцааны хамтын санхүүжилт, хадгаламжийн сертификат, үнэт цаас зээлэх үйлчилгээ, олон улсын болон нийгмийн, тогтвортой байдлын бондыг арилжих эрх зүйн орчин бүрдэв.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хөрөнгийн зах зээл огцом тэлж, 2025 оны байдлаар зах зээлийн үнэлгээ сүүлийн таван жилд 5.3 дахин өсөж 13.9 их наяд төгрөгт, биржийн арилжааны хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрсэн бол биржийн бус зах зээлээр 1.59 их наяд төгрөг, 63.89 сая ам.доллар татан төвлөрүүлсэн байна.

## Цаашдын бодлого, зорилт

Цаашид хөрөнгийн зах зээлийн тогтвортой өсөлтийг хадгалах, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор дараах чиглэлүүдэд анхаарч ажиллана. Үүнд:

- ◆ Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан (REIT)-ийн эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- ◆ Хамтын санхүүжилтийн тухай бие даасан хуулийг боловсруулах;
- ◆ Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн тогтолцоог бий болгох;
- ◆ Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх;
- ◆ Цахим технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх;
- ◆ Ногоон, тогтвортой хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх;
- ◆ Эдгээр бодлого, арга хэмжээ нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг илүү гүнзгий, төрөлжсөн, олон улсын хөрөнгө оруулагчдад нээлттэй зах зээл болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх юм.

# ЯРИЛЦЛАГА

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭ



### Банк бус санхүүгийн байгууллагын салбарт авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ

Сүүлийн таван жилийн хугацаанд банк бус санхүүгийн байгууллагын (ББСБ) салбар эрчимтэй өсөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 9.1 их наяд, зээлийн үлдэгдэл 7.2 их наяд хүрсэн байна. Үүний зэрэгцээ давхардсан тоогоор нийт харилцагчдын тоо 4.1 саяд, нийт зээлдэгчдийн тоо 3.2 саяд хүрч, санхүүгийн зах зээлд гүйцэтгэх үүрэг, нөлөө нь мэдэгдэхүйц өсчээ.

Энэхүү өсөлттэй уялдан салбарын зохицуулалт, хяналтыг боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах шаардлага улам бүр чухал болж байна. Энэ удаа Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэнтэй ярилцаж, сүүлийн үед ББСБ-ын салбарт авч хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын арга хэмжээний талаар тодрууллаа.

### Өнгөрсөн онд банк бус санхүүгийн байгууллагын салбарын эрх зүйн орчинд ямар гол өөрчлөлт, бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бэ?

2025 онд ББСБ-ын салбарын гол бүтээгдэхүүний үнэ болох зээлийн хүүг бүрдүүлж байгаа эх үүсвэрийн зардалын дийлэнх хувийг дотоодын өндөр хүүтэй зээл бүрдүүлж байсан. Иймд өндөр өртөгтэй дотоодын санхүүжилтийг хумих, харьцангуй хямд өртөгтэй гадаадын санхүүжилт

татах орчныг сайжруулах, мөн зээлдэгчдийн өрийн дарамтыг бууруулах чиглэлээр холбогдох журам, зохицуулалтад тодорхой өөрчлөлтүүдийг оруулсан. Эдгээр арга хэмжээ нь салбарын тогтвортой өсөлтийг хангах, санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилготой.

### Өндөр өртөгтэй дотоодын санхүүжилтийг хумих чиглэлээр ямар зохицуулалт хийсэн бэ?

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүнд дотоодын арилжааны банк болон мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байх, мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлэх эх үүсвэрийн хэмжээг өөрийн хөрөнгийн 60 хувиас хэтрэхгүй байх зохицуулалтыг тусгасан.

### Зээлдэгчдийн өрийн дарамтыг бууруулах чиглэлээр өмнө нь ямар бодлогын арга хэмжээг авч байсан бэ?

Санхүүгийн зохицуулах хорооноос зээлдэгчдийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор өмнөх жилүүдэд үе шаттай бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, 2022 оны 527 дугаар тогтоолоор ББСБ-аас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд, 2024 оны 556 дугаар тогтоолоор ББСБ-аас олгох бүх төрлийн хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа болон нэмээд бодлогын арга хэмжээний нөлөөг нэмэгдүүлэх, валютын гадагшлах урсгалыг хумих зорилгоор суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн зээл, үнэлгээний харьцааг 70 хувиас хэтрэхгүй байхаар тус тус тогтоож байсан.

### Өр, орлогын болон зээл, үнэлгээний харьцааг дахин бууруулах шаардлага яагаад үүссэн бэ?

Эдийн засгийн нөхцөл байдлыг харвал улсын төсвийн тэлэлт, мега төслүүдийн санхүүжилт зэрэг нь инфляцын хүлээлтийг нэмэгдүүлж, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт өсөх хандлагатай байсан ба үүний улмаас иргэдийн хэрэглээний зардал өсөх, зээлийн хүү нэмэгдэх, улмаар

өрхийн өрийн дарамт даамжрах эрсдэл бий болно гэж үзсэн. Иймээс санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлогын арга хэмжээ авах шаардлага үүссэн.

### **Энэ хүрээнд ямар шийдвэр гаргасан бэ?**

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны ээлжит IV хуралдаанаар ББСБ–аас олгох хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа болон суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн зээл, үнэлгээний харьцааг тус тус 60 хувь болгон бууруулах шийдвэрийг гаргасан.

### **Өр, орлогын харьцаа болон суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн зээл, үнэлгээний харьцаа харьцааг 60 хувиар тогтоосныг энгийн жишээгээр тайлбарлавал?**

Тухайлбал, хэрэглээний зээл авахыг хүссэн иргэний татварын дараах сарын орлого 1,000,000 төгрөг байвал тухайн иргэний зээлийн үндсэн болон хүүний сарын нийт төлбөр хамгийн ихдээ 600,000 төгрөг байна гэсэн үг. Хэрэв зээлдэгч бусад зээлийн төлбөрт сар бүр 400,000 төгрөг төлдөг бол шинээр авах хэрэглээний зээлийн сарын нийт төлбөр 200,000 төгрөгөөс хэтрэхгүй байхаар тогтоогдоно. Ингэснээр тухайн иргэн татварын дараах орлогынхоо наад зах нь 40 хувийг буюу 400,000 төгрөгийг амьжиргаа болон бусад зайлшгүй хэрэгцээндээ зарцуулах боломжтой болно.

Зээл үнэлгээний харьцааны хувьд иргэн өөрийн унаж яваа 10.0 сая төгрөгийн үнэлгээтэй суудлын автомашинаа барьцаалан хэрэглээндээ зориулсан зээл авах тохиолдолд 6.0 сая төгрөгийн зээл авах боломжтой гэсэн утгатай. Мөн шинээр хэрэглээндээ зориулан 20.0 сая төгрөгийн суудлын автомашин худалдан авах тохиолдолд 8.0 төгрөгийн урьдчилгаа төлбөрөө төлөөд 12.0 сая төгрөгөө ББСБ–ын зээлээр санхүүжүүлэх боломжтой гэсэн агуулгатай юм.

### **Энэхүү зохицуулалт зээлдэгч болон зах зээлд ямар эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна вэ?**

Санхүүгийн зах зээл дэх зохицуулалтын орчныг тодорхой хэмжээнд чангаруулж байгаа нь богино хугацаанд бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт үүсгэж болох ч нөгөө талаас зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах, өрийн дарамтыг бууруулах чухал ач холбогдолтой. Өр, орлогын харьцааг 60 хувиар тогтоож, амьжиргааны суурь хэрэгцээг

хангах орлогыг заавал үлдээх шаардлага тавьснаар зээлдэгчдийг эрсдэлээс хамгаална.

Мөн хэрэглээний зээлийн хэт өндөр өсөлт нь иргэдийн санхүүгийн сахилга бат сул байгааг илтгэдэг тул уг бодлого нь өр, орлогын харьцаа өндөр, зээлийн бүтээгдэхүүнээс хамааралтай хэрэглэгчдийн хувьд хэрэглээний зээлийн өсөлтийг аажмаар сааруулах замаар өрийн дарамтыг бууруулж, урт хугацаанд санхүүгийн сахилга бат, тогтвортой байдлыг дэмжих эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

### **Цаашид салбарын чиг хандлагыг хэрхэн харж байна вэ? Ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?**

Зээлийн мэдээллийн сангийн мэдээллээс харахад ББСБ–уудын зээлийн давхардал хэт өндөр түвшинд хүрсэн байгаа нь иргэдийн өрийн дарамт, санхүүгийн эрсдэлийн түвшин нэмэгдэх бодит эрсдэл байгааг илтгэж байна.

Иймд цаашид финтек зээлийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, зээлийн давхардлыг бууруулах, хэрэглэгчийн санхүүгийн сахилга батыг дэмжих, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээнд тулгуурласан бодлогын арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд зээлийн мэдээллийн ашиглалт, зээл олголтын шалгуур, дижитал зээлийн бүтээгдэхүүний зохицуулалтыг нарийвчлан сайжруулах асуудлууд багтана.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## 2026 ОНЫ S&P GLOBAL-ИЙН ОНЦЛОХ 10 ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЧИГ

S&P Global-аас 2026 онд тогтвортой байдлын стратеги болон шийдвэр гаргалтад хамгийн ихээр нөлөөлнө гэж үзэж байгаа салбаруудын талаар бизнесийн бүхий л салбарын тогтвортой байдал, уур амьсгал, эрчим хүчний өөрчлөлтийн чиглэлийн тэргүүлэгчид болон шинжээчдээс судалгаа авсан. Үүнээс тогтвортой санхүүжилтийн чиг хандлагыг онцолж байна.

### Тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжихэд шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ улам бүр эрчимжинэ.

Дасан зохицох болон даван туулах нь 2026 онд ажиглагдах тогтвортой байдлын онцлох сэдэв бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй эдийн засагт дасан зохицох хөрөнгө оруулалт нэмэгдэхээс гадна, даатгалын зардал, даатгалын хүртээмж буурах төлөвтэй байна.

2025 оны НҮБ-ын байгаль орчны хөтөлбөрийн дасан зохицлын ялгаа тайланд дурдсанаар уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг дасан зохицоход шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ одоогийнхоос 12–14 дахин их байна.

Албан ёсны хөгжлийн тусламж буурсаар байгаа тул тогтвортой хөгжлийн санхүүжилтийн ялгааг бууруулахад холимог санхүүжилтийн шийдлүүд, хөгжингүй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын хувийн болон дотоодын хөрөнгийн зах зээлийг оролцуулах, олон талт зээлийн байгууллагаас нэмэлтээр зээл авах зэрэг шаардлагатай.

Их 20-н бүлгийн санаачилгаар, Дэлхийн банкны батлан даалтыг сайжруулах болон олон талт зээлийн байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2021–2024 онуудад 4 хувийг өсөлтийг давсан бөгөөд энэ нь олон талт зээлийн байгууллагын тайлан тэнцлийг хурдасгах зорилготой юм.

Стандартчилагдсан, дахин давтан хэрэгжүүлэх боломжтой санхүүжилтийн бүтэц, мөн зээлийн эрсдэлийг төрөлжүүлсэн сангууд нь COP29-өөс хөгжиж буй орнуудад зориулан тогтоосон жил бүрийн 1.3 тэрбум ам.долларын уур амьсгалын санхүүжилтийн зорилтыг хангахад голлох үүрэг гүйцэтгэх боломжтой.

Шилжилтийн санхүүжилт нь 2025 онд удаашралтай байсан тогтвортой өрийн зах зээлээс 2026 онд тэргүүлэх боломжтой. Зээл болон бондын стандарт тогтоогчид богино хугацаанд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулдаг өндөр ялгаруулалттай салбаруудын төслүүдэд зориулсан шилжилтийн удирдамжийг гаргасан. Эдгээр төслүүд нь дотоодын тогтвортой

санхүүжилтийн таксономид нийцэхээс гадна энэ нь COP30 дээр зарласан уялдуулах зорилтуудаас ашиг хүртэх боломжтой юм.

Одоогийн байдлаар улс орны эдийн засгуудын нүүрстөрөгчийн үнийн тогтолцоо илүү өргөн хүрээтэй болж, түвшин нь өсөхийн хэрээр (одоогоор нийт ялгарлын 28 орчим хувийг ямар нэг хэлбэрийн нүүрстөрөгчийн үнийн зохицуулалт хамарч байна) нүүрстөрөгчгүйжүүлэх шийдлүүдийг дэмжихийн зэрэгцээ засгийн газрын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Байгаль хамгааллыг багтаасан ногоон төслүүдээс нүүрстөрөгчийн эрх /кредит/ бий болгох нь хөгжиж буй эдийн засгуудад санхүүжилт татахад дэмжлэг үзүүлж чадна. Мөн холимог санхүүжилтийн өсөн нэмэгдэж буй зорилтууд байгальд суурилсан төслүүдийг хамрах болж, Халуун орны ойг үүрд хамгаалах сан (Tropical Forest Forever Facility, TFFF) нь 74 хөгжиж буй зах зээлд хэрэгжих төслүүдэд зориулан жил бүр 4 тэрбум ам.доллар татан төвлөрүүлэх зорилт тавиад байна.

Худалдааны бодлогын тодорхойгүй байдлын үед хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх дэлхийн зохицуулалт сорилт хэвээр байна. Тогтвортой хөгжлийн зорилтууд нь хиймэл оюун ухааны дэд бүтцийг дэмжих, батлан хамгаалах, аюулгүй байдал, технологийн салбаруудын санхүүжилтийн өрсөлдөөнийг улам бүр нэмэгдүүлж, боломжит хөрөнгө оруулалтыг тухайн салбарууд руу чиглүүлж байна.

### By the numbers: Sustainable issuance trends



Source: S&P Global Ratings.  
© 2026 S&P Global.

Эх сурвалж: S&P Global's Top 10 Sustainability Trends to Watch in 2026

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## ТУЗ–ИЙН 2026 ОНД АНХААРАХ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН 7 ЧИГ ХАНДЛАГА

### *Өмнөх дугаарын үргэлжлэл.*

#### **Чиг хандлага 4. Кибер эрсдэл — стратегийн асуудал**

Кибер эрсдэл 2026 онд ихэнх компанийн хувьд бизнесийн хамгийн том эрсдэлийн нэг хэвээр байна. Бизнесийн үйл ажиллагаа дижитал хэлбэрт шилжиж, мэдээллийн үнэ цэнэ өсөн нэмэгдэхийн хэрээр кибер халдлагын давтамж, арга хэлбэр илүү нарийсч, боловсронгуй болсоор байна.

Генератив ХОУ–ийн хөгжлийн нөлөөгөөр хуурамч цахим шуудан, видео, аудио автоматажсан халдлагын хэрэгсэл үүсгэх нь урьд өмнөхөөс илүү хялбар болсон. Иймээс кибер аюулгүй байдал нь мэдээллийн технологийн асуудал биш, байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа, санхүү хөрөнгө, нэр хүнд, зохицуулалтын эрсдэлийг ч мөн дагуулж байдаг стратегийн сэдэв болсон.

Жишээлбэл, CrowdStrike–ийн 2024 оны программын шинэчлэлтээс үүдэлтэй дэлхий даяарх доголдол нь гуравдагч этгээдийн технологид хэт найдах, нийлүүлэлтийн сүлжээнд үүсэх эрсдэл зэрэг нь бодит хохирол үүсгэж болохыг тод харуулсан. Тиймээс ТУЗ кибер хамгаалалт, дотоод хандалтын бодлого, халдлагыг илрүүлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөө, сургалт зэргийг нэгдсэн системтэйгээр авч үзэж, компанийн стратеги, хөрөнгө оруулалтын шийдвэртэй уялдуулах шаардлагатай.

#### **Чиг хандлага 5. Бодит цагийн хяналт — засаглалын тогтолцоо**

Уламжлалт загвараар ТУЗ нь улирал тутамд хуралдаж, тухайн хугацааны гүйцэтгэлээ эргэн харж, тайлан сонсох хэлбэр давамгайлсан байв. Харин өнөө үед нэгдсэн, бодит цагийн хяналтын самбар (dashboard)–т тулгуурласан засаглалын тогтолцоо руу шилжих хандлага эрчимжиж байна. Энэ нь санхүүгийн гол үзүүлэлт, эрсдэлийн индикатор, комплайнс, дотоод хяналт, байгаль орчин, нийгэм засаглал (ESG), хүний нөөцийн хэмжигдэхүүнийг нэг цонхонд төвлөрүүлж, ТУЗ–ийн гишүүд цаг алдалгүй мэдээллээр ханган, шийдвэр гаргалтаа илүү нотолгоонд суурилуулах боломж олгодог.

Diligent зэрэг засаглалын платформын шийдлүүд нь “том зураг”–ийг нэг дороос харах, стратегийн эрсдэлийг эрт илрүүлэх, хямралын үед мэдээлэлд тулгуурласан шуурхай шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлдэг. Ингэснээр ТУЗ–ийн хурлыг баримт танилцуулахад бус, стратегийн хэлэлцүүлэг, шийдвэр гаргалтад чиглүүлэх боломж нэмэгдэнэ.

#### **Чиг хандлага 6. Ур чадвар, залгамж халаа — стратегийн асуудал**

Хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны хүлээлт мэдэгдэхүйц өөрчлөгдөж байна. Залуу үеийнхний хувьд уян хатан ажлын байр, утга учиртай, нийгэмд эерэг нөлөөтэй ажил, тогтвортой хөгжил болон компанийн соёл илүү чухал болжээ.

ТУЗ–ийн гишүүдийн дундаж нас харьцангуй өндөр хэвээр байгаа боловч ч тэднийг орлох, залгамж халааг бэлтгэсэн компани харьцангуй цөөн байна. Энэ нь залгамж халааны эрсдэл, мэдлэг, туршлагын хомсдол үүсгэх аюултай. Тиймээс компаниуд залуу үеийнхийг дотоод сургалт, менторшип, төслийн удирдлага, дижитал ур чадвар болон удирдах чадамжийг системтэй хөгжүүлэх зэрэг асуудлыг стратегийн хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлага нэмэгдэж байна.

Мөн ажил солих давтамжийг “тогтворгүй байдал” гэхээсээ илүү “боломж эрэлхийлж, өсөх эрмэлзэлтэй” мэргэжилтний хэв маяг гэж харах хандлага түгээмэл болж байна.

ТУЗ–ийн хувьд хосолмол, зайнаас ажиллах бодлогыг байгууллагын түвшинд бодитоор дэмжих, ирээдүйн удирдагчдыг ТУЗ–ийн дэргэдэх хороо, ажлын хэсгүүдэд үе шаттай оролцуулах, залгамж халааны төлөвлөгөөг тодорхой, хэмжигдэхүйц зорилттой болгох нь онцгой ач холбогдолтой.

#### **Чиг хандлага 7. ТУЗ–ийн үнэлгээ — өрсөлдөх давуу тал**

ТУЗ–ийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг үнэлэх нийтлэг практик дэлхий даяар өсөж байна. Гэхдээ зарим компаниудад энэ үнэлгээ жил бүр бөглөдөг хэлбэр төдий асуулга болж, бодит сайжруулалт, өөрчлөлтөд төдийлөн хүрэхгүй байх тохиолдол цөөнгүй.

Судалгаагаар ТУЗ–ийн гишүүдийн дийлэнх нь өөрсдийн зөвлөлийн гүйцэтгэлийг “өндөр” гэж үнэлдэг боловч тэдний тал хувь нь “дор хаяж нэг гишүүнийг солих шаардлагатай” гэж үзсэн нь үнэлгээ бодит, шударга, үр дүнтэй явагдахгүй байгааг илтгэнэ.

ТУЗ үнэлгээг үр дүнтэй болгохын тулд зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, ур чадварын матриц, хороодын үүрэг, мэдээлэл авах сувгийн чанар, хуралдааны оролцоо, стратегийн хэлэлцүүлэг, гүйцэтгэх удирдлагатай харилцах харилцаа зэргийг цогцоор нь авч үзэх шаардлагатай.

Үнэлгээний үр дүн нь үйл ажиллагааны төлөвлөгөө, сайжруулалтын зорилтууд, гишүүдийн хөгжил, сургалтын хөтөлбөр, залгамж халааны төлөвлөгөөтэй уялдсан байх ёстой. Ингэснээр үнэлгээг “хийсэн” гэж тэмдэглээд өнгөрөх бус, компанийн засаглалын чанарыг бодитоор сайжруулах, хөрөнгө оруулагч, зохицуулагч болон бусад оролцогч талын итгэлийг нэмэгдүүлэх давуу тал болж чадна.

Эх сурвалж: [www.diligent.com](http://www.diligent.com)

# ФИНТЕК БА РЕГТЕК

## ФИНТЕК САЛБАР ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО



Хурдтай хөгжиж буй финтек салбарт эмэгтэйчүүд инновац болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна. Эмэгтэйчүүд нь уламжлалт банк, хөрөнгө оруулалтын тогтолцоог шинэчилж, санхүүгийн үйлчилгээний хүртээмж дутмаг бүлгүүдэд чиглэсэн, бодит хэрэгцээнд нийцсэн шийдлүүдийг боловсруулан өөрсдийн хувь нэмэр оруулсаар байна. Судалгаагаар жендерийн зөрүүг бууруулах нь дэлхийн хэмжээнд 700 тэрбум ам.долларын орлогын боломжийг нээж, жендерийн тэгш байдал нь илүү өндөр өгөөж, инновацыг бий болгодог гэж дурджээ.

2025 онд хиймэл оюун ухаан, нэгдсэн санхүүгийн үйлчилгээ (embedded finance)–ний хөгжилтэй уялдан финтек салбар тэлэхийн хэрээр эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмэр улам бүр ач холбогдолтой болж байгааг онцолсон байна.

### АНХДАГЧДААС НӨЛӨӨ БҮХИЙ МАНЛАЙЛАГЧИД ХҮРТЭЛ

Финтек салбар дахь эмэгтэйчүүдийн түүх нь эрэгтэйчүүд зонхилсон санхүүгийн орчинд өөрийн орон зайг бий болгох оролдлогоос эхэлсэн ба 2010–аад оны эхэн үеэс, дэлхийн санхүүгийн хямралын дараах шинэчлэлийн үед эмэгтэйчүүдийн үүсгэн байгуулсан төлбөрийн болон дижитал зээлийн шийдлүүд нь уламжлалт санхүүгийн тогтолцоонд бодитой нөлөө үзүүлж эхэлсэн. Жэйн Фрэйзер “Сити” банкны анхны эмэгтэй гүйцэтгэх захирал болж томилогдсоноор санхүүгийн салбар дахь удирдлагын бүтэц аажмаар өөрчлөгдөж эхэлснийг харуулсан чухал үйл явдал болсон. Цар тахлын дараа энэ чиг хандлага илүү эрчимжиж, зайнаас ажиллах боломж болон дижитал технологид тулгуурлан блокчэйн, санхүүгийн хүртээмжийн чиглэлээр шинэ шийдэл хэрэгжүүлсэн эмэгтэйчүүдийн үүсгэн байгуулсан гарааны бизнесүүдийн тоо мэдэгдэхүйц өссөн. Мөн 2010–аад оны дунд үеэс эмэгтэйчүүдийн удирдсан анхны хөрөнгө оруулалтын сангууд байгуулагдаж, энэ нь салбарын хувьд чухал ахиц дэвшил болсон. Үүнтэй зэрэгцэн санхүү, финтек салбарын томоохон компаниудад эмэгтэй удирдах ажилтнуудын оролцоо аажмаар нэмэгджээ.

### СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2025 оны хувьд финтек салбар эмэгтэйчүүдийн оролцоонд чиглэсэн тодорхой ахиц дэвшил болон санхүүгийн тэгш бус байдлыг зэрэг харуулсан жил байлаа. Эмэгтэйчүүдийн үүсгэн байгуулсан финтек компаниуд өнгөрсөн жил нийт 3.4 тэрбум ам.долларын хөрөнгө босгож, дэлхийн технологийн салбарын нийт санхүүжилтийн 11.7 хувийг эзэлсэн байна. Финтек салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж байгаа хэдий ч, эдийн засаг, хөрөнгө татах боломжийн хувьд харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна.

Түүнчлэн финтек компаниудын удирдлагын бүтэц дэх

эмэгтэйчүүдийн оролцоо бага байгааг онцолсон. Тодруулбал, удирдлагын бүтэц дэх үүсгэн байгуулагчид болон хамтран үүсгэн байгуулагчдын ердөө 7.7 хувь нь эмэгтэй, гүйцэтгэх хорооны гишүүдийн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 18.2 хувь бөгөөд энэ нь таван хүн тутмын нэгээс ч бага байна. Харин гүйцэтгэх захирлуудын эмэгтэйчүүдийн эзлэх хувь 4.0 хувь байна. Түүнчлэн финтек компаниудын зөвхөн 40 хувь нь зөвлөлдөө эмэгтэй гишүүнтэй байгаа нь салбарын оролцоог илүү тэгш, хүртээмжтэй болгох шаардлагатайг харуулж байна. Африк болон Латин Америкийн хөгжиж буй зах зээлд эмэгтэйчүүдэд чиглэсэн финтек үйлчилгээний нөлөөгөөр эмэгтэйчүүдийн хөрөнгө оруулалтын хувь харьцангуй өндөр байгаа нь бүс нутгийн онцлог, боломжийг илтгэж байна.

### **ФИНТЕКИЙН ГОЛ НӨЛӨӨ БҮХИЙ МАНЛАЙЛАГЧ ЭМЭГТЭЙЧҮҮД**

Финтек салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэнээр тэдний манлайлал финтек салбарыг шинэчилж байна. Жэйн Фрэйзер (Jane Fraser) нь “Сити” банкны гүйцэтгэх захирал (CEO) бөгөөд 2025 онд дижитал хувиргалт ба тогтвортой санхүүгийн чиглэл дэх тэргүүлэгчдийн нэгд багтсан. Мөн Лори Бир (Lori Beer), “Жей Пи Морган Чейз” компанийн глобал мэдээллийн технологийн захирал, хиймэл оюун ухаан ба кибер аюулгүй байдлын чиглэлээр амжилттай ажиллаж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх инновацыг хэрэгжүүлдэг. Шарлотт Хогг (Charlotte Hogg), “Виза Европ” компанийн гүйцэтгэх захирал бөгөөд дижитал төлбөр ба санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэхэд анхаарч байна. Камилла Гизек (Camilla Giesecke), “Кларна” компанийн өргөтгөлийн тэргүүлэгч (Chief Expansion Officer), “одоогоор худалдаж аваад дараа төлөх” (buy-now-pay-later) загварын хөгжилд тогтвортой байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлж байна. Төлбөрийн салбарт, Кристи Карстенсен (Kristy Carstensen) “ACI Worldwide” ба Сима Чиббер (Seema Chibber) “Жей Пи Морган Чейз Пэймэнтс” компанид хуурамч үйлдлээс урьдчилан сэргийлэх, олон улсын сүлжээний менежментэд тэргүүлж ажиллаж байна. Шинээр гарч буй удирдагчдын дунд Келли Зитлоу (Kelly Zitlow) нь ипотекийн финтек чиглэлд ажиллаж байна.

### **ФИНТЕК САЛБАР ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СОРИЛТ БА БОЛОМЖУУД**

Финтек салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж, тодорхой түвшинд ахиц дэвшил гарсан хэдий ч, сорилтуудтай нүүр тулсаар байна. Судалгаагаар эмэгтэй үүсгэн байгуулагчид хөрөнгө оруулагчидтай уулзах үед салбарын мэдлэг, ур чадварын талаар эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2.8 дахин их асуулттай тулгардаг нь жендерийн тэгш бус байдал байсаар байгааг илтгэж байна. Санхүүжилтийн ялгаа ч хадгалагдаж, эмэгтэй удирдлагатай компанийн авсан хөрөнгө дунджаар 5.2 сая ам.доллар, харин эрэгтэй удирдсан компаниудын хөрөнгө дунджаар 11.7 сая ам.долларт хүрч байна. АНУ-ын финтек салбарт бүх эмэгтэй багийн эзэмшилд ногдсон хөрөнгө оруулалт ердөө 1 хувиар хязгаарлагддаг нь салбарын эмэгтэйчүүдийн санхүүжилтийн боломжийг хязгаарлаж байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн дунд төлөөлөл бага байгаа нь эмэгтэйчүүдийн санхүүжилт авах магадлалыг хязгаарлаж байгаа ч нөгөө талаас эмэгтэй түнштэй компаниуд эмэгтэйчүүдийг санхүүжүүлэх магадлал 2.3 дахин их байдаг байна.

Финтек салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо нь инновацыг дэмжих, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, улмаар эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэсэн хэдий ч эмэгтэй удирдлагатай болон үүсгэн байгуулсан компаниудын хувьд санхүүжилтийн тэгш бус байдал хадгалагдсаар байгаа нь энэ чиглэлд бодлого, зохицуулалт болон дэмжих арга хэмжээг зорилтот байдлаар хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Түүхэн анхдагчдаас эхлээд өнөөгийн манлайлагч эмэгтэйчүүдийн хувь нэмэр нь финтек экосистемд финтек экосистемийг илүү олон талт, хүртээмжтэй болгож буйг харуулж байна. Цаашид эмэгтэй удирдлагатай бизнесүүд болон тэдгээрийн санал санаачилгыг дэмжих нь салбарын тогтвортой өсөлт, өрсөлдөх чадварыг хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Эх сурвалж:

OmniWave Финтек. (2025). Финтек салбарын ирээдүйг тодорхойлж буй эмэгтэйчүүд. OmniWave Финтек–Шинэчлэлийн Санхүүгийн Технологи. <https://omniwavefintech.com/women-shaping-the-future-of-fintech/>

# СУДЛААЧИЙН ИНДЭР

## САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

*Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх болно.*

### Гүйцэтгэсэн:

СЗХ, ЗЗСХГ, Ахлах референт П.Байгалмаа, baigalmaa@frc.mn  
 СЗХ, ЗЗСХГ, Ахлах мэргэжилтэн Б.Даваамаа, davaamaa@frc.mn  
 СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, gal Б.Гал @frc.mn  
 СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, sainbileg Б.Сайнбилэг @frc.mn

### ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд дэлхийн санхүүгийн салбарт тогтвортой хөгжил, байгаль орчныг хамгаалах зорилготой “ногоон хөрөнгө оруулалт”, “тогтвортой санхүүжилт”, “ESG тайлагнал” зэрэг ойлголтууд өргөн хэрэглэгдэх болсон. Гэвч энэхүү чиг хандлагатай зэрэгцэн зарим байгууллага бодит бус, төөрөгдүүлсэн мэдээлэл түгээж өөрсдийгөө байгальд ээлтэй мэтээр сурталчлах “ногоон угаалт” (greenwashing) түгээмэл ажиглагдаж байна.

Энэхүү судалгааны зорилго нь санхүүгийн салбар дахь ногоон угаалтын мөн чанар, илрэх хэлбэр, шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, олон улсын стандарт болон улс орнуудын зохицуулалтын жишгийг судалж, Монгол Улсад тохирох бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, кейс судалгаа, олон улсын харьцуулалтын арга зүйг ашиглав. Судалгааны үр дүнд ногоон угаалт нь санхүүгийн зах зээлийн итгэлцэл, ил тод байдлыг алдагдуулж, тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд сөрөг нөлөөлтэйг тогтоов.

### УДИРТГАЛ

Эдийн засаг, нийгмийн хөгжил нь байгаль орчны тогтвортой байдалтай салшгүй холбоотой болсон өнөө үед дэлхий дахинд уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн хомсдол, экосистемийн доройтол зэрэг асуудал хурцаар тавигдаж байна. Үүнтэй уялдан “ногоон хөгжил”, “тогтвортой санхүүжилт”, “байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) зарчим” зэрэг ойлголтууд дэлхийн санхүүгийн системд гүнзгий нэвтэрч, бодлого, шийдвэр гаргалтын салшгүй хэсэг боллоо.

Энэхүү чиг хандлага өргөжихийн хэрээр зарим байгууллагууд байгаль орчинд ээлтэй мэт ташаа мэдээлэл түгээж, нэр хүнд, ашиг орлогоо нэмэгдүүлэх “ногоон угаалт” (greenwashing) гэх үзэгдэл гарах болсон.

Санхүүгийн салбар дахь ногоон угаалт нь бусад салбараас илүү төвөгтэй илрэх хандлагатай бөгөөд ялангуяа “ногоон зээл”, “ногоон бонд”, “тогтвортой хөрөнгө оруулалт” гэх мэт нэрийн дор бодит бус эсхүл дутуу мэдээлэл түгээдэг нь санхүүгийн байгууллагуудад итгэх хөрөнгө оруулагчдын шийдвэр гажуудан улмаар тэдний итгэлцэл, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулж байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь санхүүгийн салбар дахь ногоон угаалтын суурь ойлголт, шалтгаан, хэлбэр, эрсдэлийг тодорхойлж, олон улсын стандартууд (GRI, SASB, ISO 14030) болон улс орнуудын (Европын холбоо, АНУ, Сингапур) зохицуулалтын туршлагыг харьцуулан судлах замаар Монгол Улсад ногоон угаалтаас урьдчилан сэргийлэх, хязгаарлах, таслан зогсоох бодлогын зөвлөмж боловсруулахад оршино. Судалгаанд үндэслэн ил тод, баталгаатай ESG тайлагнал, хөндлөнгийн аудитын тогтолцоо, нэгдсэн стандартуудыг хэрэгжүүлэх нь ногоон угаалтаас үүдэх эрсдэлийг бууруулах хамгийн үр нөлөөтэй хэрэгсэл гэж үзэж байна.

Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, олон улсын харьцуулалт, кейс судалгаа болон чанарын дүн шинжилгээний аргыг ашигласан. Судалгааны үр дүн нь Монгол Улсад ил тод, хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

## НОГООН УГААЛТЫН СУУРЬ ОЙЛГОЛТ

Энэхүү бүлэгт ногоон угаалт (*greenwashing*)–ын үүсэл, утга агуулга, олон улсад хэрэглэж буй тодорхойлолт, илрэх хүчин зүйл ба хэлбэр, түүний улмаас үүсэх эрсдэл, түүнээс сэргийлэх үндсэн зарчмыг авч үзнэ.

### Ногоон угаалтын тодорхойлолт

“Ногоон угаалт” хэмээх нэр томъёог анх байгаль орчны идэвхтэн Жей Вестервелд (1986) онд ашигласан. Тэрээр Фижи аралд аялж байхдаа нэгэн амралтын газрын үүдэнд “байгаль орчныг хамгаалахын тулд алчуураа дахин ашиглана уу” гэсэн уриалгатай таарсан.

Жей Вестервеллийн үзэж буйгаар нийтлэлдээ уг уриалга нь өнгөц харахад зочид буудлыг экологийн хариуцлагатай, мэт сэтгэгдэл төрүүлж байсан боловч бодит байдал дээр алчуур угаахтай холбоотой зардал (цахилгаан эрчим хүч, ариутгалын бодис, хөдөлмөрийн зардал)–аа хэмнэх зорилготой байгаль орчноо дээдэлдэг үйлчлүүлэгчдийн сэтгэл зүйн мэдрэмжийг онилсон маркетингийн арга болохыг мэдэж шүүмжилсэн<sup>1</sup>–ээр гарч ирсэн.

Өнөөдөр “Ногоон угаалт” гэх нэр томъёог өргөн хэрэглэж байгаа ч эрх бүхий байгууллагаас тодорхойлсон албан ёсны тодорхойлолт байхгүй ч дараах байдлаар илэрхийлж байна. Тухайлбал:

Олон улсын үнэт цаасны комисс (2021) “Хөрөнгийн удирдлагын тайлан”–д ногоон угаалтыг “тогтвортой байдлын практик эсвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний тогтвортой байдалтай холбоотой шинж чанаруудыг буруугаар тайлбарлах явдал” гэж тодорхойлсон;

Их Британийн Хуулийн нийгэмлэг “ногоон угаалтыг байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг бодит бус хэт эерэгээр харуулсан үйлдэл” гэж үздэг;

Европын холбоонд Европын санхүүгийн хяналтын байгууллагууд ногоон угаалтыг “тогтвортой байдалтай холбоотой мэдэгдэл, үйл ажиллагаа, харилцаа холбоо нь аж ахуйн нэгж, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний бодит тогтвортой байдлын дүр төрхийг тодорхой бөгөөд шударгаар тусгаагүй үйлдэл”.

Санхүүгийн салбарын хүрээнд ногоон угаалт гэдэг нь ерөнхийдөө компанийн санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө

орзуулалтын стратеги нь байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж буй мэтээр илэрхийлсэн боловч үнэн хэрэгтээ худал, хуурмаг, төөрөгдүүлсэн мэдэгдэл, төлөвлөлтийг хэлнэ.

Энэ нь тухайн компани байгаль орчинд цэвэр эерэг эсвэл төвийг сахисан нөлөө үзүүлэхийг санал болгосон тохиолдолд тэдний бизнесийн загвар эсвэл үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нь байгаль орчинд хор хөнөөл учруулж болзошгүй тохиолдолд илэрдэг гэсэн үг юм.

Ногоон угаалт хийх нь санаатай байхыг шаарддаггүй, өөрөөр хэлбэл ногоон угаалт хийж буй аж ахуйн нэгж санаатайгаар төөрөгдүүлэхийг зорьсон эсэхээс үл хамааран ногоон угаалга үйлдсэн гэж үзэж болно.

### Ногоон угаалтын шалтгаан ба ангилал

Ногоон угаалт нь дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр үүдэлтэй үүсдэг гэж үзэж болно.

#### 1. Гадаад хүчин зүйлс:

– *Эрэлт нэмэгдэх* – “ногоон” буюу тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт өсөх нь компаниудад ногоон дүр төрх бий болгох дарамт үүсгэдэг. Тухайлбал: 2022 онд First Insight судалгаагаар Z үеийнхний 73 хувь, миллениалын 68 хувь нь тогтвортой бүтээгдэхүүнд илүү мөнгө төлөхөд бэлэн гэсэн нь эрэлт бий болгосон.

– *Хэтрүүлсэн сурталчилгаа* – бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой байдлын тодорхойлолттой холбож, бодитой бус байдлаа нуун сурталчлах.

– *Мэдээллийн зөрүү* – байгууллагын түвшинд тогтвортой байдлын үнэлгээ, тайлагналын ил тод, найдвартай байдлыг хангахтай холбоотой мэдээллийг зөрүүтэй тайлагнах.

– *Гуравдагч талын дарамт* – ТББ–ууд болон олон нийтийн зүгээс хяналт, зохицуулалтын хэрэгжилтийг хангах шаардах шахалт үзүүлэх.

#### 2. Үйл ажиллагааны буюу дотоод хүчин зүйлс:

– *Зохицуулалтын цоорхой, зөрчил* – хууль эрх зүйн шаардлагууд тодорхой бус, уялдаа сул байх.

– *Засаглалын сул тал* – удирдлага, чадавх хүний нөөцийн

<sup>1</sup>Gellweiler, S.; Higson, P. The SAGE International Encyclopedia of Travel and Tourism; SAGE Publications, Inc.: Thousand Oaks, CA, USA, 2017; Volumes 1–4, pp. 544–546.

мэдлэгэ туршлага дутмаг.

– *Хязгаарлагдмал нөөц* – хяналт, дагаж мөрдөх систем сул, дотоод чадамж хангалтгүй.

– *Мэдээллийн чанар* – хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тогтвортой байдалтай холбоотой мэдээлэл бүрэн бус, үнэн зөв биш, баталгаажуулалт сул байх.

– *Шошго ба мэдээллийн буруу хэрэглээ* – стандарт, тэмдэглэгээний тодорхой бус, мөн хөрөнгө оруулагчид ил болон хэрэглэгчдийн мэдлэг дутмаг.

Ногоон угаалт үйлдэгдэх тохиолдлыг "Террачойс"<sup>2</sup> байгаль орчны судалгааны компани (2007)–ны гүйцэтгэсэн судалгаандаа "Ногоон угаалтын 7 нүгэл" (*The Seven Sins of Greenwashing*) гэж ангилсан болно. Үүнд:

Нүгэл №1: Далд худалдааны нүгэл (*The Sin of Hidden Trade-Off*): Бүтээгдэхүүний зөвхөн нэг хэсэг "ногоон" шинжийг онцолж, харин үйлдвэрлэлийн явцад гардаг бусад сөрөг нөлөөллийг зориуд орхигдуулахыг хэлнэ. Жишээ нь, дахин боловсруулсан цаасаар хийсэн бүтээгдэхүүнийг сурталчлахдаа түүнийг үйлдвэрлэхэд их хэмжээний энерги, ус зарцуулсныг нуух.

Нүгэл №2: Нотлогдохгүй нүгэл (*The Sin of No Proof*): Энэ нь ямар нэг баримт, нотолгоо, гуравдагч талын үнэлгээгүйгээр "ногоон" гэх мэдэгдэл хийх явдал юм.

Нүгэл №3: Тодорхой бус байдлын нүгэл (*The Sin of Vagueness*): "Байгальд ээлтэй", "ногоон", "эко" зэрэг тодорхой стандарт, хууль эрх зүйн тодорхойлолтгүй, хоёрдмол утгатай үгсээр сурталчилгаа хийх. Эдгээр үгс нь хэрэглэгчдийг төөрөгдүүлэхэд ашиглагддаг.

Нүгэл №4: Худал мэдээлэл (*The Sin of Fibbing*): Энэ нь худал, хуурамч мэдэгдэл хийх эсвэл огт байхгүй байж сертификат, стандарттай мэтээр харагдуулахыг хэлнэ. Жишээ нь, стандартын шаардлага хангаагүй атлаа "Органик" гэх хуурамч шошго ашиглах.

Нүгэл №5: Үл хамаарах нүгэл (*The Sin of Irrelevance*): Байгаль орчинд хамааралгүй эсвэл хуулиар зайлшгүй шаардагддаг шинж чанарыг сурталчилгаандаа онцлох. Жишээ нь,

бүтээгдэхүүнээ CFC (хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодис) агуулаагүй гэж сурталчлах.

Нүгэл №6: Хоёр муугийн бага нүгэл (*The Sin of Lesser of Two Evils*): Бага хортойг нь онцлох. Хэдийгээр тухайн бүтээгдэхүүн нь "ногоон" мэт боловч, үнэндээ байгаль орчинд сөрөг нөлөөтэй байх тохиолдол. Жишээ нь, "эко" тамхи эсвэл "ногоон" тээврийн хэрэгсэл (бензинээр ажилладаг) гэж сурталчлах.

Нүгэл №7: Хуурамч шошго шүтэх нүгэл (*The Sin of Worshipping False Labels*) Энэ нь хэрэглэгчдийг төөрөгдүүлэхийн тулд хуурамч гэрчилгээ эсвэл шошго бий болгох. Ингэснээр хэрэглэгчдийг ямар нэгэн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ хууль ёсны зөвшөөрөл авсан гэж итгүүлэх. Энэхүү хуурамч гэрчилгээтэй холбоотой асуудал нь далайн салбарт нэлээд байдаг. 2001 онд Олон улсын далайн байгууллага (IMO) гэрчилгээг хуурамчаар үйлдсэн 12,635 тохиолдол илрүүлжээ.

Харин Planet Tracker<sup>3</sup> судалгааны байгууллага (2023)–аас ногоон угаалтыг илрэх шинж чанараас нь хамааруулж ерөнхийдөө Террачойс–ын ангилсантай адил ч дараах байдлаар авч үзсэн. Үүнд:

Ногоон гэрэлтүүлэг (*Green-lighting*): Байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны сөрөг нөлөөг бууруулах бодит алхам хийгээгүй байж олон нийтээс нууцалж тэдний анхаарлыг сарниулах зорилгоор байгаль орчинд ээлтэй санаачилга, жижиг үйлдлээ онцолж сурталчилдаг. Ийм төрлийн ногоон угаалт нь, олон нийтийн дунд уг байгууллага нь байгаль орчныг хамгаалахад бодитой хувь нэмэр оруулдаг гэсэн ойлголтыг төрүүлдэг байна. Жишээ нь: Нефтийн томоохон компаниуд жил бүр мод тарих кампанит ажил зохион байгуулдаг ч нийт хөрөнгө оруулалтын 90 гаруй хувь нь уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийг дэмжсэн хэвээр байдаг.

Ногоон шошго (*Greenlabelling*): Байгууллагууд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх бодит нөлөөллийг хэтрүүлэн харуулах, эсвэл буруу ойлголт төрүүлэх зорилгоор "ногоон", "байгальд ээлтэй", "100%

<sup>2</sup>TerraChoice Environmental Marketing Inc. The Seven Sins of Greenwashing: A Study of Environmental Claims in Consumer Markets. 2007 ([https://sustainability.usask.ca/documents/Six\\_Sins\\_of\\_Greenwashing\\_nov2007.pdf](https://sustainability.usask.ca/documents/Six_Sins_of_Greenwashing_nov2007.pdf)) <https://www.greenbusinessbenchmark.com/archive/7-sins-of-greenwashing>

<sup>3</sup><https://planet-tracker.org/greenwashing-growing-increasingly-sophisticated-says-planet-tracker/>

байгалийн” зэрэг зохицуулалтгүй, тодорхой бус нэр томьёо, шошго, зураг ашиглах явдлыг хэлнэ. Энэ нь хэрэглэгчдийг төөрөгдүүлж, тухайн бүтээгдэхүүнийг экологийн хувьд аюулгүй хэмээн итгүүлдэг.

**Чимээгүй ногоон (Greenhushing):** Энэ угаалт нь олон нийтийн шүүмжлэлд өртөхөөс эмээх, ил тод мэдээлэл хийхдээ шаардлагатай баримт, нотолгоог дутуу өгөх, байгаль орчинд ээлтэй бодлого, үйл ажиллагаагаа зориудаар олон нийтэд мэдээлэхээс зайлсхийх, санаатайгаар чимээгүй байх зэрэг байдлаар илэрдэг. Жишээлбэл: 2022 онд олон улсын 1,200 гаруй компанийн тогтвортой байдлын тайланг судлахад 23 хувь нь зорилгоо дутуу илэрхийлсэн буюу “чимээгүй” хандлагыг баримталсан болохыг South Pole, 2022 судалгаанд дурдсан байна.

**Ногоон зайлалт (Greenwashing):** Байгууллагууд байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй дүр эсгэх, хариуцлагаас зайлсхийхийн тулд ESG зорилтуудыг тогтмол өөрчлөх, шинэчлэх зэрэг олон нийтийг төөрөгдүүлдэг. Тухайлбал: Автомашин үйлдвэрлэгч 2025 он гэхэд нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулна гэж зорилт тавьсан ч хангаж

чадахгүй болмогц хугацаагаа 2040 он болгож сунгах нь бодит өөрчлөлтгүй, хариуцлагаас зайлсхийж буй үйлдэл юм.

**Ногоон шилжилт (Green-shifting):** Байгууллага өөрийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн хариуцлагыг хүлээхийн оронд хэрэглэгчдэд эсвэл бусад оролцогч тал руу шилжүүлж тэднийг илүү ногоон сонголт хийхийг уриалж, бурууг шилжүүлдэг. Үүнд: Хуванцар сав үйлдвэрлэгчид “хэрэглэгчид дахин боловсруулахаар тушаахгүй байгаа нь асуудал” хэмээн бурууг хэрэглэгчид рүү чиглүүлэх.

**Ногоон бөөгнөрөл (Greencrowding):** Байгууллага бие даан хариуцлага хүлээхээс зайлсхийх зорилгоор олон байгууллагын хамтарсан кампанит “ногоон” санаачилгад нэгдэх замаар өөрийн байгууллагын сөрөг нөлөөллийг далдалдаг. Жишээ авч үзвэл: GFANZ (Glasgow Financial Alliance for Net Zero)–д зарим санхүүгийн байгууллагууд нэгдсэн ч бодит зээл, хөрөнгө оруулалтын бүтэц нь нүүрстөрөгчийн ялгаруулалт буурахгүй өндөр хэвээр байна.

## САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ НОГООН УГААЛТ

Энэхүү бүлэгт санхүүгийн салбар дахь ногоон угаалтын илрэл, түүний өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс, нийтлэг хэлбэрүүд болон олон улсын томоохон кейсүүдийг авч үзнэ.

### Санхүүгийн салбарын оролцоо ба ногоон угаалтын өсөлт

Санхүүгийн байгууллагууд нь ногоон хөгжилд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх гол хэрэгсэл тул тэдгээрийн ил тод байдал, хариуцлага онцгой ач холбогдолтой. Иймээс тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэмжих олон улсын санаачилгад санхүүгийн салбарын оролцоог нэмэгдүүлэхийг тууштай уриалж ирсэн. Үүнд:

Энэ хүрээнд Дэлхийн Банкны харьяа Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)–ын удирдлага дор “Экваторын зарчмууд”<sup>4</sup> (2003)–ыг баталсан. Экваторын зарчмууд нь төслийн санхүүжилтийн нийгэм, байгаль орчны эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах суурийг бүрдүүлдэг. Өдгөө 100 гаруй санхүүгийн байгууллага уг зарчмыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Мөн Нэгдсэн Үндэсний Байгууллагаас “Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчим” (Principles for Responsible Investment)<sup>5</sup>–ыг санаачилж хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад ESG–ын хүчин зүйлсийг тусган хариуцлагатай хангахыг уриалсан. Энэхүү зарчмыг 5,300 гаруй байгууллага дэмжиж, албан ёсоор гарын үсэг зураад байна.

<sup>4</sup>Equator principles Action report 2023 page 3

<sup>5</sup><https://www.unpri.org/about-us/what-are-the-principles-for-responsible-investment>

Парисын хэлэлцээр (2015)-ийн зорилтуудын нэг нь санхүүгийн урсгалыг хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжилд чиглүүлэх<sup>6</sup> явдал юм. Учир нь уг зорилт хяналттай тогтвортой санхүүгүйгээр хэрэгжих боломжгүй<sup>7</sup> болохыг олон улсын түвшинд онцолсон.

Шотландын Глазго хотноо зохион байгуулагдсан НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн бага хурал (COP26)-д оролцсон 70 их наяд ам.долларын хөрөнгийг удирдаж буй дэлхийн 160 гаруй санхүүгийн байгууллага 2050 он гэхэд цэвэр хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэглэх зорилтыг дэмжин, албан ёсоор амлалт өгсөн.<sup>8</sup> Энэхүү санаачилгад санхүүгийн салбарыг голлох үүрэг гүйцэтгэнэ хэмээжээ. Өнөөдөр дэлхийн 193 орон тогтвортой хөгжлийн төлөөх арга хэмжээнүүдийг дэс дараатайгаар авч хэрэгжүүлэх, хүлэмжийн хийг бууруулахаар амлалт өгч хэрэгжүүлж байна.

Үүний нэг илрэл 2023 онд баталсан Куньмин–Монреалийн “Биологийн олон янз байдлын конвенц” ба үүний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн 30 хувийг байгаль хамгаалах зорилтод нийцүүлэх шаардлагыг тусгасан.<sup>9</sup>

Мөн НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд хүн төрөлхтөн 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг тэг болгох зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээнд дэлхийн 193 орон тогтвортой хөгжлийн төлөөх арга хэмжээнүүдийг дэс дараатайгаар авч хэрэгжүүлэх амлалт өгч, хүлэмжийн хийг бууруулах даалгавар авсан.<sup>10</sup>

Дээр дурдсан олон улсын амлалтуудаас харахад санхүүгийн салбар нь нөөцийг хуваарилах үндсэн механизмын хувьд байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөрөө стратегийн чухал оролцогч болж байна.

Гэвч байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, цэвэр хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэглэх зорилгод хүрэх олон улсын амлалтууд нь ногоон эдийн засгийн эрэлтийг огцом өсөж, үүнтэй зэрэгцэн “ногоон угаалт” үзэгдэл өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ талаар:

Лондоны Биркбекийн Их Сургуулийн харьяа Инновацын менежментийн судалгааны төв (CIMR) (2020)<sup>11</sup> ESG-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, томоохон хөрөнгийн багцтай компаниудын зан төлөвийг шинжилж судалжээ. Судалгааны дүгнэлтэд компаниуд ESG-ын хүрээнд олсон ололт амжилтаа хэтрүүлэн үнэлж, бодит байдлаас зөрүүтэй мэдээлэл түгээх замаар ногоон угаалт хийж буйг онцолсон байна.

Үүнийг нотлох өөр нэгэн баримт нь Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) хэмжигдэхүүнээр мэргэшсэн мэдээллийн компани болох RepRisk-ийн 2023 оны есдүгээр сард нийтэлсэн тайланд дэлхийн банк санхүүгийн үйлчилгээний салбарт ногоон угаалтын 148 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 86-аар их буюу 70 хувиар өссөн<sup>12</sup> гэж дурджээ.

Дэлхийн хэмжээнд ногоон, нийгэм, тогтвортой байдал, тогтвортой байдалтай холбоотой бонд зэрэг тогтвортой бонд гаргах нь 2021 онд нийлээд 1 их наяд доллароос давж, 2018 онтой харьцуулахад бараг 5 дахин өснө гэж S&P Global үзэж байна.

<sup>6</sup>Article 2.1 of the Paris Agreement indicates as objectives: (1) to hold the increase in the global average temperature to well below 2°C above pre-industrial levels and pursue efforts to limit the temperature increase to 1.5°C (article 2.1a), (2) to promote climate resilience development (article 2.1b), (3) Article 2.1c [https://unfccc.int/sites/default/files/english\\_paris\\_agreement.pdf](https://unfccc.int/sites/default/files/english_paris_agreement.pdf)

<sup>7</sup>Intergovernmental Panel on Climate Change (IPCC), Climate Change Synthesis Report; page 1553., 2023 [https://www.ipcc.ch/report/ar6/syr/downloads/report/IPCC\\_AR6\\_SYR\\_SPM.pdf](https://www.ipcc.ch/report/ar6/syr/downloads/report/IPCC_AR6_SYR_SPM.pdf)

<sup>8</sup><https://www.un.org/en/climatechange/biggest-financial-players-back-net-zero>

<sup>9</sup>Principles for Responsible Investment <https://www.unpri.org/about-us/what-are-the-principles-for-responsible-investment>


<sup>10</sup>'Go Zero' арга хэмжээг танилцуулах нь – Тэг рүү тэмүүлэх нь | Unread Today

<sup>11</sup><https://eprints.bbk.ac.uk/id/eprint/30701/1/Greenwashing%20in%20environmental%20social%20and%20governance%20disclosures%20from%20Ellen%20Yu.pdf>

<https://www.tradefinanceglobal.com/posts/report-greenwashing-incidents-up-70-globally-2023/>


<sup>12</sup><https://www.tradefinanceglobal.com/posts/report-greenwashing-incidents-up-70-globally-2023/>

Зураг. Тогтвортой өрийн хэрэгсэл



Үүнтэй зэрэгцэн Дэлхий санхүүгийн салбарт л гэхэд 2018 оноос 2023 он хүртэл ногоон угаалтын тохиолдол ойролцоогоор 10 дахин нэмэгджээ.

Зураг. Санхүүгийн салбар дахь ногоон угаалтын тохиолдол



Нийгэм, шилжилтийн болон тогтвортой байдалтай холбоотой хэрэгслүүд зэрэг тогтвортой санхүүжилтийн шинэ хэлбэрүүд газар авч байгаа тул хөрөнгө оруулагчид ногоон болон тогтвортой байдлын угаалтад санаа зовнил нь нэмэгдсээр байна.

### Ногоон угаалтын илрэх байдал

Ногоон угаалт нь санхүүгийн салбарт дараах үндсэн хэлбэрүүдээр нийтлэг илэрч байна. Үүнд:

- ◆ Төсөл, хөтөлбөр: Зарим тохиолдолд хөрөнгө оруулагчдад “ногоон” гэж тодорхойлсон төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх урам зориг өгдөг ч, бодит байдалд тэр нь экосистемд сөргөөр нөлөөлөх. Жишээ нь: Малайзын Селангор мужийн Сиера Алам төсөл нь “байгаль орчинд



ээлтэй, нийгмийн сайн сайхны төлөө” гэх шошгоор хөрөнгө татсан ч бодит байдалд уулын бэл хэсгийг ухаж, экосистемийг доройтуулсан, үерийн эрсдэлийг нэмэгдүүлсэн, олон зүйлийн амьтан, ургамлын амьдрах орчныг устгасан нь тогтоогдсон. 2022 оны тайланд тус бүс нутаг 4000 га ойгоо алдаж, биологийн төрөл зүйл буурсан гэж дурджээ.

- ◆ Ногоон бонд: Тус бонд гаргагчид татан төвлөрүүлсэн



хөрөнгийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой төслүүдэд зарцуулна гэж амладаг. Гэвч зарим тохиолдолд уг хөрөнгийг анхны зорилгоос өөр зүйлд ашиглах, эсвэл үр нөлөөг хангалтаай хэмжихгүй, нотолгоо дутмаг байх явдал ажиглагддаг. Жишээ нь, JBS S.A компани 2021 онд 3.2 тэрбум ам.долларын “тогтвортой байдлын холбоотой бонд” гаргасан ч Амазоны ой модод үзүүлэх сөрөг нөлөөллийг бодитоор төлөвлөгөөгүй, хүлэмжийн


хийн бууралтаа нотолгоогүй, орхигдуулсан гэж буруутгагдаж байжээ (2024).

- ◆ Ногоон зээл: Энэ нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой



төслүүдэд зориулагдах байтал тодорхой шалгуур, үнэлгээний системгүйгээр олгосон тохиолдолд ногоон угаалт болж хувирдаг. Тухайлбал, Австралийн Үндэсний банк 2021 онд нүүрсний экспортын боомтод “ногоон” зээл олгосон нь бодит байдал дээр нүүрс ашиглалтын хугацааг уртасгасан тул ногоон угаалтын жишээ болсон.

- ◆ Ногоон шошго: Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний



бодит агуулга, үр нөлөөгүйгээр “экологийн”, “тогтвортой”, “ногоон” гэх мэт нэр томъёог ашиглаж, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдыг төөрөгдүүлэх практик юм. Жишээ нь, Lloyds Banking Group олон нийтийн газарт “Бид чулуужсан түлшний хараат байдлаа бууруулж, санхүүгийнхээ жинг цэвэр, сэргээгдэх эрчим хүч рүү чиглүүлэх замаар эрчим хүчний шилжилтийг дэмжих үүрэг хүлээсэн.” хэмээн сурталчилсан ч үнэн хэрэгтээ чулуужсан түлшний санхүүжилтээ үргэлжлүүлж байсан нь, төөрөгдүүлэх мэдээлэлд тооцогдсон.

ESG мэдээллийн тайлан: Байгаль орчны нөлөөллийг дутуу тайлагнах эсвэл хэтрүүлсэн мэдээлэл оруулж тайлагнадаг.



Жишээ нь Rio Tinto компани байгаль орчны нөлөөллийг бууруулах, усны менежментийг сайжруулах амлалт өгсөн ч 2023 оны тогтвортой байдлын тайланд усны бохирдлын асуудлаа дурдаагүй орхигдуулсан гэж хөрөнгө оруулагчдын зүгээс шүүмжлүүлсэн.

### Дэлхийг доголгосон томоохон кейсүүд

Дэлхийн хэмжээнд донсолгосон томоохон компаниудын үйлдсэн “ногоон угаалт”-ын жишээнүүдийг авч үзье.

#### 3.3.1. DWS



Германы хөрөнгө удирдлагын компани DWS Group нь Франкфурт хотод төвтэй, 40 гаруй оронд салбартай Deutsche Bank-ийн охин компани бөгөөд хөрөнгө удирдлагын салбарт тэргүүлэгчдийн нэгт тооцогддог. Тус компани 2020 оноос хойш өөрсдийгөө “ESG бол бидний Дезоксирибонуклейн хүчил (ДНХ)-ийн нэг хэсэг”, “ESG-ын чиглэлээр манлайлагч” хэмээн сурталчилж ирсэн. Гэвч АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (SEC) болон Германы Франкфуртын

прокурорын газар хамтран мөрдөн шалгалтыг эхлүүлж, 2022 оны тавдугаар сард DWS болон Deutsche Bank-ийн Франкфурт дахь салбаруудыг нэгжиж улмаар компанийн сурталчилсан ESG хөрөнгө оруулалтын зарим бүтээгдэхүүн нь бодит байдал дээр тогтоосон шалгуурыг хангаагүй, сурталчилгааны мэдээлэл нь хэтрүүлэгтэй, төөрөгдүүлсэн болохыг тогтоосон.

Ийнхүү 2023 онд АНУ-ын SEC-ийн зүгээс DWS-т 19 сая ам.долларын торгууль оногдуулсан бол, 2025 онд Германы Франкфуртын прокурорын газар 3 жилийн турш хийсэн мөрдөн шалгалтын эцэст DWS-г ногоон угаалт үйлдсэн хэмээн дүгнэж, Deutsche Bank-ны нийт орлогод үндэслэн 25 сая еврогийн (ойролцоогоор 27 сая ам.доллар) торгууль ногдуулжээ. Энэ нь ESG зөрчилтэй холбоотойгоор Германд оногдуулсан хамгийн өндөр дүнтэй шийтгэлд тооцогдож байна.

DWS компанийн зүгээс эдгээр торгуулийг хүлээн зөвшөөрч, дотоод хяналт шалгалт, баримт бичгийн бүрдүүлэлт болон маркетингийн үйл ажиллагаандаа сайжруулалт хийх арга хэмжээ авсан болохоо мэдэгдсэн.



#### **Goldman Sachs**

Goldman Sachs Asset Management (GSAM) нь Goldman Sachs группийн хөрөнгө удирдлагын салбар компани бөгөөд хувь хүн, байгууллага, тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан зэрэг харилцагчдад чиглэсэн төрөл бүрийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог. Тус байгууллага нь ойролцоогоор 2.5 их наяд ам.долларын хөрөнгийг удирдаж, дэлхийн 30 гаруй оронд салбартай томоохон тоглогчдын нэг юм.

2020 оноос GSAM компани нь ESG хөрөнгө оруулалтыг эрчимтэй сурталчилж, бүх төрлийн хөрөнгө оруулалтын шийдвэрт ESG-ын шалгуурыг нэгтгэн тусгаж ажилладаг хэмээн мэдэгдэж байсан. Тухайлбал тус компанийн US Equity ESG Fund болон International Equity ESG Fund нэртэй

хоёр сан нь "Бид хөрөнгө оруулалтын үйл явцдаа ESG-ын хүчин зүйлсийг тусган хэрэгжүүлдэг.", "Манай ESG сангууд хатуу шалгуурын дагуу хөрөнгө оруулалт хийдэг", "Хөрөнгө оруулагчид өөрсдийн үнэт зүйлтэй нийцсэн хөрөнгө оруулалт хийх боломжтой" гэх мэт зар сурталчилгааг олон нийтэд түгээсэн. SEC нь 2021 оноос хойш ESG-тэй холбоотой хөрөнгө оруулалтын ил тод байдал, тайлагналд онцгой анхаарал хандуулж ESG сангуудыг шалгах тусгай нэгж байгуулж хяналт шалгалтыг эхлүүлсэн. Ингэснээр 2022 онд тус байгууллагын ESG чиглэлийн хөрөнгө оруулалтын бодит байдал болон сурталчилгааны зөрүүтэй холбоотой дотоод шалгалт хийж "Зарим хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа ESG үнэлгээний шалгуур, мэдээлэл ашиглаагүй", "сурталчилгаа нь бүх хөрөнгөд ESG шалгуур хэрэглэдэг гэсэн ойлголт төрүүлж байсан боловч бодит үйл ажиллагаанд зарим сан нь энэ шалгуурыг огт ашиглаагүй", "ESG үнэлгээний баримтжуулалт, дотоод хяналтын процесс хангалтгүй" болохыг тогтоосон. SEC-ийн зүгээс GSAM-ийг "худал мэдэгдэл, дутуу тайлагнал хийсэн" хэмээн үзэж, 4 сая ам.долларын торгууль оногдуулсан. Тус компани энэхүү шийтгэлийг хүлээн зөвшөөрч, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээ мэдэгдсэн:

ESG хөрөнгө оруулалтын процессын ил тод байдлыг нэмэгдүүлэх,  
Сурталчилгаа, баримт бичгийн агуулгыг шалгах хяналтыг сайжруулах,  
ESG үнэлгээний шалгуурыг бүх сандаа ашиглах.

### BNY Mellon

BNY Mellon Investment Adviser Inc. нь Bank of New York Mellon Corporation-ийн хөрөнгө удирдлагын салбар компани. Тус компани нь Goldman Sachs-тай ижил төстэй буюу ESG хөрөнгө оруулалтын талаар худал мэдээлэл өгсөн гэх хэргээр 2022 онд SEC-ээс шалгалт орсон. SEC-ээс тус компанийн сурталчилгаанууд нь бодит байдлыг гуйвуулсан болохыг тогтоогдсон. Үүнд тодорхой хөрөнгө оруулалтууд нь огт ESG үнэлгээ хийгдээгүй, эсвэл ESG шалгуурын дагуу биш байхад, уг санд орсон бүх хөрөнгийг ESG шалгуураар бүрэн дүгнэсэн мэтээр илэрхийлсэн нь хөрөнгө оруулагчдад худал мэдээлэл өгч, шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлсөн гэж дүгнэжээ. Иймээс SEC нь BNY Mellon Investment Adviser Inc.-ийн үйлдлийг Хөрөнгө оруулалтын зөвлөхийн тухай хуулийн 206(2) дахь заалт "хуурмаг, төөрөгдүүлсэн мэдээлэл тараах", 206(4)-7, 8 дэх "бодлогын дагуу зохих хяналт хийхгүй байх", 34(b) дэх "хөрөнгө оруулалтын компанийн хуульд үндэслэсэн мэдээллийг худал илэрхийлэх"-ыг тус тус зөрчсөн хэмээн үзэв. Иймд SEC-ийн зүгээс 2022 онд тус компанид 1.5 сая ам.долларын торгууль оногдуулжээ.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ "Biggest Financial Players Back Net Zero." United Nations, <https://www.un.org/en/climatechange/biggest-financial-players-back-net-zero>.
- ◆ "BNY Mellon Charged for ESG Quality Review Misstatements." Peters & Peters, <https://www.petersandpeters.com/case/bny-mellon-charged-for-esg-quality-review-misstatements>.
- ◆ Climate change and European Aquatic Resources (CERES) & United Nations Environment Programme (UNEP). (1997). Global Reporting Initiative (GRI) Standards. Amsterdam: GRI Secretariat. , <https://www.globalreporting.org/>.
- ◆ "Equator Principles Action Report 2023." Equator Principles, p. 3.
- ◆ "Green Claims." European Commission, 2012 [https://environment.ec.europa.eu/topics/circular-economy/green-claims\\_en](https://environment.ec.europa.eu/topics/circular-economy/green-claims_en).
- ◆ "Green Guides." Federal Trade Commission (FTC), <https://www.ftc.gov/news-events/topics/truth-advertising/green-guides>.
- ◆ "Greenwashing Incidents up 70% Globally in 2023." Trade Finance Global, <https://www.tradefinanceglobal.com/posts/report-greenwashing-incidents-up-70-globally-2023/>.

- ◆ Securities and Exchange Commission. (2022). Rule 35d-1 “Naming Rule” — Investment Company Names. Washington D.C.: SEC
- ◆ “ISO – International Organization for Standardization.” ISO, <https://www.iso.org/home.html>.
- ◆ “SASB Standards.” IFRS Foundation, <https://sasb.ifrs.org/>.
- ◆ “Save Shah Alam Community Forest.” New Straits Times, <https://shahalamforest.org/wp/residents-nature-lovers-and-ngos-unite-in-last-ditch-battle-to-save-shah-alam-community-forest-from-imminent-destruction-new-straits-times-jun-2024/>.
- ◆ “Singapore Green Labelling Scheme.” Global Ecolabelling Network, <https://globalecolabelling.net/organisation/singapore-green-labelling-scheme>.
- ◆ “Sustainability Certifications.” Ceres Cert, <https://www.ceres-cert.de/en/home>.
- ◆ “What Are the Principles for Responsible Investment?” UN PRI, <https://www.unpri.org/about-us/what-are-the-principles-for-responsible-investment>.
- ◆ RepRisk. (2023). Greenwashing Risk in the Financial Sector: 2023 Report. Zurich: RepRisk AG.
- ◆ “Монголын тогтвортой санхүүгийн холбоо” 2022. [https://www.mongolbank.mn/file/files/documents/press\\_conference/20220812\\_01.pdf](https://www.mongolbank.mn/file/files/documents/press_conference/20220812_01.pdf). Accessed
- ◆ Gellweiler, S., and P. Higson. The SAGE International Encyclopedia of Travel and Tourism. Vols. 1–4, SAGE Publications, 2017, pp. 544–546.
- ◆ Greenwashing: 3 Case Studies. Sustainability Unlocked, <https://sustainabilityunlocked.com/videos/greenwashing-3-3-case-studies>.
- ◆ Intergovernmental Panel on Climate Change (IPCC). Climate Change 2023: Synthesis Report. IPCC, 2023, p. 1553, [https://www.ipcc.ch/report/ar6/syr/downloads/report/IPCC\\_AR6\\_SYR\\_SPM.pdf](https://www.ipcc.ch/report/ar6/syr/downloads/report/IPCC_AR6_SYR_SPM.pdf).
- ◆ U.S. Securities and Exchange Commission. “SEC Charges BNY Mellon Investment Adviser for Misstatements and Omissions Concerning ESG Considerations.” SEC.gov, Press Release No. 2022-86, <https://www.sec.gov/newsroom/press-releases/2022-86>. Accessed 10 June 2025.
- ◆ OECD. (2022). Green claims and market transparency. OECD Publishing
- ◆ Francesca, A. (2025). Greenwashing in finance. Journal of Sustainable Business, 12(3), 45–59.



## ЗЭЭЛ АВАХАД АНХААРАХ АЛТАН ДҮРЭМ

**Зээл** гэдэг нь өнөөдөр авсан мөнгөө маргааш ХҮҮ-тэй нь буцаан төлөх амлалт юм.



САРЫН БҮРИЙН ЗЭЭЛИЙН НИЙТ ТӨЛБӨР САРЫН ЦЭВЭР  
ОРЛОГЫН **40%**-ААС ХЭТРЭХГҮЙ БАЙХ !



### ЗЭЭЛ АВАХЫН ӨМНӨ БОД

- ✓ Орлогоо бодитоор тооц
- ✓ Одоогийн бүх зээлээ нэгтгэн бич
- ✓ Хүү, шимтгэлийн **НИЙТ ӨРТӨГ**-ийг асуу, тооц
- ✓ Нэг удаагийн мөнгө, олон удаагийн үүрэг



### АНХААР

40%-д багтахгүй бол **ЗЭЭЛ** авах зөв үү?

## ХЯЛБАР ШАЛГАХ ХУУДАС



Сарын цэвэр орлого: \_\_\_\_\_ төгрөг



Орлогын 40 хувь: \_\_\_\_\_ төгрөг



Одоогийн бүх зээлийн төлбөр: \_\_\_\_\_ төгрөг

Шинээр авах зээлийн төлбөр: \_\_\_\_\_ төгрөг

### ӨӨРӨӨСӨӨ АСУУ:

- Зээлийн хэмжээ орлогод тохирч байна уу?
- Орлого буурахад хэрэглэх нөөц мөнгөтэй юу?
- Зээлийн төлбөр амьжиргаанд санхүүгийн дарамт болохгүй юу?

ҮГҮЙ ҮГҮЙ



ХЭРЭВ ЭДГЭЭР АСУУЛТАД **“ҮГҮЙ”** ГЭЖ ХАРИУЛБАЛ  
ЗЭЭЛ АВАХААС АЛЬ БОЛОХ ТАТГАЛЗ

### БҮҮ МАРТ:

Зээл — боломж.



Хэтрүүлбэл — дарамт.



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**ГРЕНЛАНДЫН МАРГААНТАЙ ХОЛБОГДСОН ТРАМПЫН ТАРИФЫН МЭДЭГДЭЛ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРГУЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭВ.**



АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Гренланд арлыг худалдан авахыг зөвшөөрөх хүртэл Европын зарим улсад тариф ногдуулна гэж мэдэгдсэний дараа дэлхийн санхүүгийн зах зээл хэлбэлзэлд орж, евро доод түвшинд хүрэв.

Доналд Трамп мэдэгдэлдээ Дани, Норвеги, Швед, Франц, Герман, Нидерланд, Финланд болон Их Британи зэрэг улсаас АНУ-д импортлох бараанд ирэх хоёрдугаар сарын 01-нээс эхлэн нэмэлт 10 хувийн тариф ногдуулна, хэрэв тохиролцоонд хүрэхгүй тохиолдолд уг тарифыг зургаадугаар сарын 01-нээс 25 хувь болгон нэмэгдүүлнэ гэж онцолсон. Энэ мэдэгдэл нь Европын STOXX 600 индексийг хоёр сарын хамгийн их өдөр тутмын уналт руу түлхэж, экспортын хамааралтай Германы DAX болон Францын CAC 40 индексүүд нэг өдрийн дотор 1 хувиас дээш уналттай байв.

Зураг: Гренландын маргааны улмаас өнгөрсөн 7 долоо хоногт доод цэгт хүрлээ.

Euro exchange rate against the dollar



Note: Latest prices as of early Asia trade on Monday

Source: LSEG | Dhara Ranasinghe

Euro touches fresh 7-week lows in early trade on Greenland worries

“Capital Economics-ийн тооцоолсноор АНУ-ын тариф нэмэгдэхэд хамгийн эмзэг орнууд нь Их Британи болон Герман байх бөгөөд 10 хувийн тариф эдгээр орны ДНБ-ийг ойролцоогоор 0.1 хувиар бууруулж, харин 25 хувийн тариф 0.2–0.3 хувийн уналт дагуулах эрсдэлтэй” гэж дүгнэв.

Ийм нөхцөл байдал дунд аюулгүй хөрөнгөд тооцогдох алтны үнэ огцом өсөж, 2026 оны нэгдүгээр сарын 19-ний өдрийн даваа гарагт 1 хувиас дээш нэмэгдэж унц нь 4,689.39 ам.долларт хүрч, түүхэн дээд түвшинд тогтлоо. Металлын үнэ энэ оны нэгдүгээр сард бараг 8 хувиар өссөн бол өнгөрсөн онд нийтдээ 64 хувиар өсөөд байсан юм.

Гэхдээ тарифын мэдэгдэлтэй холбоотой зах зээлийн сөрөг хариу үйлдэл удаан үргэлжилсэнгүй. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Давос дахь Дэлхийн эдийн засгийн форумын үеэр Европт чиглэсэн тарифын сүрдүүлгээ зөөлрүүлж, Гренландын асуудлаар тохиролцооны суурь хэлэлцээр эхэлсэн хэмээн мэдэгдсэний дараа зах зээлүүд тодорхой хэмжээнд тогтворжлоо.

Үүний зэрэгцээ Европын холбоо 93.0тэрбум еврогийн хариу татварын багцыг зургаан сарын хугацаагаар түр зогсоох төлөвлөгөө боловсруулж, худалдааны хэлэлцээрийг сэргээх оролдлого хийж байна.

Зах зээлийн оролцогчид Трампын мэдэгдлийг худалдааны

зөрчил бүрэн хурцдахаас зайлсхийх дохио хэмээн хүлээн авч, богино хугацаанд болгоомжлол саарсан ч, АНУ–Европын харилцаанд тодорхойгүй байдал бүрэн арилаагүй хэвээр байгааг шинжээчид анхааруулж байна.



Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

### БНХАУ–ЫН НҮҮРСНИЙ ИМПОРТ 2025 ОНД ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЛЭЭ.

БНХАУ 2025 оны 12 дугаар сард нийт 58.6 сая тонн нүүрс импортолсон нь сарын дүнгээр бүх цаг үеийн дээд үзүүлэлт болсныг тус улсын Гаалийн албаны статистик харууллаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 12 орчим хувиар, харин 11 дүгээр сараас 33 хувиар өссөн үзүүлэлт юм. Бүтэн жилийн дүнгээр нийт импорт нь 490 сая тонн болж, өмнөх онд тогтоосон дээд үзүүлэлтээс 9.6 хувиар буурсан байна. Харин 12 дугаар сард нүүрсний импорт нь цойлоход дотоод болон гадаад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байгаа бөгөөд Индонезийн засгийн газар 2026 оноос нүүрсний экспортын шинэ тариф ногдуулах дохио өгснөөр худалдан авагчид нийлүүлэлтээ түргэсгэж, нөөцөө бүрдүүлэхээр яарсан байна.

Түүнчлэн дэлхийн хамгийн том ган үйлдвэрлэгч БНХАУ өнгөрсөн 12 дугаар сард нийт 11.3 сая тонн гангийн бүтээгдэхүүн тээвэрлэн гаргасан нь гангийн экспорт түүхэн дээд түвшинд хүрчээ. Бээжингээс гаргасан мэдэгдэлд 2026 оноос гангийн экспортод лицензийн шаардлага тавих болсноо зарласны дараагаар гангийн үйлдвэрүүд экспортын тээвэрлэлтийг урьдчилан татсан нь ийнхүү нөлөөлсөн гэж үзэж байна.

Эх сурвалж: <https://www.reuters.com/>, БНХАУ–ын Гаалийн мэдээллийн сайт: [www.customs.gov.cn](http://www.customs.gov.cn)

### БНХАУ–Д ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН САЛБАРЫН УНАЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙНА.

БНХАУ–ын орон сууцны үнэ унаж, үл хөдлөх хөрөнгийн салбарт хямрал дөрөв дэх жилдээ үргэлжилж байна. Өнгөрсөн оны 12 дугаар сард БНХАУ–ын томоохон 70 хотод



шинэ орон сууцны үнэ өмнөх сараасаа 0.45 хувиар буурсан нь сүүлийн нэг жилд байгаагүй огцом уналт гэж үзэж байна. Тус салбарын уналт нь 2021 оноос эхэлсэн бөгөөд гол шалтгаанд Evergrande, Country Garden зэрэг том хөгжүүлэгч, барилгын компаниуд өрийн дарамтад орж төслүүдээ хойшлуулсан, сул эрэлтээс шалтгаалан бизнесүүд болон өрхүүдийн зээл авах сонирхол мэдэгдэхүйц буурсны улмаас уналтад орсон байна. БНХАУ–д 2025 онд банкны зээлийн нийт хэмжээ 16.27 их наяд юань (2.33 их наяд ам.доллар) болж, 2018 оноос хойших хамгийн доод түвшинд хүрчээ. Үүнээс гадна хөдөө орон нутгийн банкнууд барьцаанд авсан үл хөдлөх хөрөнгөө 20–30% хямдруулсан ч борлуулж чадахгүй, худалдан авагчдын сонирхол сул хэвээр байгаа нь хэрэглэгчийн эрэлт хангалтгүй байгааг баталж байгаа юм. Дэлхийн хоёр дахь том эдийн засагтай улсын бодлого тодорхойлогчид орон сууцны зах зээлийн уналтыг тогтоон барих, худалдан авагчийн эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд илүү зорилтот бодлого хэрэгжүүлэхгүй бол 2026 онд үнэ уналт үргэлжилж, салбарын хямрал удаан хугацаанд хадгалах магадлалтай гэж шинжээчид дүгнэжээ.


Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр


S&P 500 /<sup>^</sup>GSPC/

**6,950.23** +34.62 (+0.50%)



Nikkei 225 /<sup>^</sup>N225/

**53,141.23** +258.31 (+0.49%)




FTSE 100 /<sup>^</sup>FTSE/

**10,148.90** +5.41 (+0.05%)



NASDAQ Composite (<sup>^</sup>IXIC)

**23,601.36** +100.11 (+0.43%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

 **1-110**  
Авлигыг мэдээлэх утас